СҮХБААТАР ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН АРДЧИЛАЛ МОНГОЛЫН
ЗАЛУУЧУУДЫН ХОЛБОО

MonCertf

# КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД АЮУЛГҮЙ АЖИЛЛАХ ГАРЫН АВЛАГА

*/хоёрдугаар хэвлэл/*

# SAFE WORKING DURING COVID-19

*Handbook*

*/Second Edition/*



СҮХБААТАР ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН АРДЧИЛАЛ МОНГОЛЫН
ЗАЛУУЧУУДЫН ХОЛБОО

MonCertf

# КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД АЮУЛГҮЙ АЖИЛЛАХ

*Гарын авлага*

Улаанбаатар хот
2021 он

# ЦАР ТАХЛЫН ҮЕД АЮУЛГҮЙ АЖИЛЛАХ

***Гарын авлага***

**Төслийг санаачлагч:**

**Г.Билгүүн -** Ерөнхий захирал, МонСертф ХХК

**Төслийн багийн гишүүд:**

**Ш.Батбаяр**

**П.Цэцэгмаа**

**Б.Энхтөгс**

**Б.Үүрийнтуяа**

**Б.Батболд**

**Д.Батбаяр**

СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН АРДЧИЛАЛ МОНГОЛЫН ЗАЛУУЧУУДЫН ХОЛБОО

MonCertf

Номын хэмжээ: А5
Хэвлэсэн газар: Оргилпресс ХХК хэвлэх үйлдвэр.



# ӨМНӨХ ҮГ

КОВИД-19 цар тахал дэлхий даяар тархан хүн төрөлхтөний өдөр тутмын ажил хөдөлмөр, амьдралын хэв маягт эргэлт буцалтгүй нөлөө үзүүлэх нь нэгэнд тодорхой болжээ. Хүүхэд залуусын сурч боловсрохоос эхлээд төр хувийн хэвшлийн бүхий л байгууллагын үйл ажиллагаанд урьд өмнө тохиолдож байгаагүй хүндрэл бэрхшээл тулгарлаа. Зайнаас сурч боловсрох, ажиллаж хөдөлмөрлөх нь хэдийгээр энгийн зүйл мэт боловч цар тахлын үед халдвар хамгааллын дэглэм сахин эрүүл мэнд болон эдийн засгийн хувьд гарз хохирол багатай, үр бүтээлтэй байх нь бидний хувьд нэн шинэ дадал зуршлуудыг шаардаж байна. Иймд Сүхбаатар дүүргийн Нийгмийн Ардчилал Монголын Залуучуудын холбооны залуус бид нийгмийн хариуцлагынхаа хүрээнд цар тахлын үед ажиллах олон улсын стандартуудыг Монгол Улсын хэмжээнд хэрэглэх боломжийг бий болгох үүднээс энэхүү гарын авлагыг боловсруулах, нийтийн хүртээл болгох ажилд хамтран оролцлоо. Энэхүү стандартыг Монгол Улсын хууль эрхзүйн орчинд тохируулан хэрэглэхэд ямар нэгэн хүндрэл үүсэхгүй бөгөөд Та бүхний эрхэлж буй бизнес, үйл ажиллагаанд цар тахлын аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах томоохон дэмжлэг болно гэж найдаж байна.

Та бүхэнд эрүүл энхийг хүсэн ерөөе!

СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН АРДЧИЛАЛ МОНГОЛЫН
ЗАЛУУЧУУДЫН ХОЛБООНЫ ТЭРГҮҮН Ш.БАТБАЯР




# ӨМНӨХ ҮГ

КОВИД-19 цар тахал нь хөдөлмөрийн харилцааны хэв маягийг орвонгоор нь эргүүлж, ажил олгогч эздэд урьд өмнө хэзээ ч тохиолдож байгаагүй бэрхшээлтэй тулгарч байна. Цар тахлын үед бизнесээ авч үлдэхийн зэрэгцээ үр өгөөж, бүтээмжтэй ажиллахын тулд ажилтнуудаа хамгаалах талаар иж бүрэн заавар өгөх шаардлагатай байна.

Улс, байгууллага болон тус тахалтай янз бүрээр дор бүрнээ тэмцэж байгаа ч бэлэн нэгдсэн удирдамж, заавар, сайн туршлагийг төдийлэн мэдэхгүй, судлаагүй байна. Иймд Монголын хамгийн анхны олон улсаар итгэмжлэгдсэн (multi-national accredited) менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллага МонСертф нь өөрийн олон улсад бүртгэлтэй, баталгаажуулсан, коджуулсан, хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүлэх аудиторуудтайгаа Олон Улсын стандарт “ISO/PAS 45005 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент - КОВИД 19 цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий заавар”, бусад менежментийн тогтолцооны стандарт, сайн туршлага, сургалтын материал, олон улсын болон үндэсний хууль эрх зүйтэй нийцүүлэн энэхүү гарын авлагыг боловсруулан Монголчууддаа өргөн барьж байна.

Энэхүү гарын авлага нь байгууллага болон ажилтнууд цар тахалтай холбоотой эрсдэлийг хэрхэн удирдах талаар байгууллага, ажилтанд зориулсан практик зөвлөмжийг багтаасан ба үйл ажиллагаагаа сэргээж байгаа, цар тахлын үеэр үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа болон үйл ажиллагаагаа шинээр эхлүүлж байгаа аль ч байгууллагуудад хэрэглэхэд тохиромжтой.

Тус гарын авлага нь бизнесийн төрөл, байгууллагын үзүүлж буй үйлчилгээ, хэмжээ, онцлогоос үл хамааран бүхий л байгууллагад хэрэглэгдэх боломжтойгоор боловсруулагдсан юм.

Нарийвчилсан дэлгэрэнгүй тайлбар, зөвлөгөө, сургалт авахыг хүсвэл тус гарын авлагыг боловсруулсан ажлын хэсгийн гишүүдэд хандан уу.

Хүндэтгэсэн,

Монсертф ХХК-ийн Ерөнхий захирал:

Г.Билгүүн

Улаанбаатар хот

2021.05.01

**Цар тахлын үед аюулгүй ажиллах хэрэглэх заавар**

**“КОВИД-19”**



## 1. Хамрах хүрээ

Энэхүү баримт бичиг нь бүх төрлийн, бүх салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудад хамааралтай бөгөөд үүнд:




Энэхүү баримт бичиг нь бүх төрлийн ажилтнуудыг (жишээлбэл, байгууллага, компаний үндсэн ажилтнууд, үйлчилгээ эрхлэгч гадны компаний ажилтнууд, гэрээт гүйцэтгэгчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, агентлагийн ажилтнууд, ахмад настай ажилтнууд, хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд болон анхны тусамж үзүүлэгчид), бусад сонирхогч талууд (Зочид, гадна талаас нэвтэрч буй бусад хүмүүс орно) хэрхэн ажиллах, үйл ажиллагаа эрхлэх талаар зааварчилсан.

Энэхүү баримт бичиг нь эмнэлзүйн, эрүүл мэндийн болон бусад орчинд халдвар хамгааллын тусгай протоколыг хэрэгжүүлэх

зааварчилгааг өгөхөд зориулагдаагүй болно.

*Тэмдэглэл: Холбогдох хууль тогтоомж, удирдамжийг эдгээр нөхцөлд ажиллагсдад зориулж Засгийн газар, зохицуулагч агентлагууд, эрүүл мэндийн байгууллагууд өгдөг. (хавсралт В – Ковид 19 цар тахалтай холбоотойгоор Монгол улсад дагаж мөрдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журмын жагсаалт)*

## 2. Норматив иш таталт

Энэ баримт бичигт норматив иш таталт байхгүй болно.

## 3. Нэр томъёо ба тодорхойлолт

Энэхүү баримт бичигт дараахь нэр томъёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

| | |
|---|---|
| 3.1 Байгууллага | Хариуцлага, эрх мэдэл, харилцаа холбоо бүхий чиг үүрэгтэй, зорилтууддаа хүрэхэд чиглэсэн хувь хүн эсвэл бүлэг хүмүүс. |
| 3.2 Ажилтан | Байгууллагын хяналт дор явагддаг ажил эсвэл энэ ажилтай хамааралтай үйл ажиллагааг гүйцэтгэж буй хувь хүн (3.1) |
| 3.3 Ажлын байр | Байгууллагын хяналтан дор байдаг (3.1) хүн байх шаардлагатай, эсвэл ажил хийхээр очих шаардлагатай газар. Тайлбар 1: Байгууллагын ажлын байрны үүрэг хариуцлага нь ажлын байран дахь хяналтын түвшингээс хамаарна.<br>Тайлбар 2: Ажлын байр гэдэгт ажилтнуудын (3.2) өөрсдийн гэр, бусад хүмүүсийн гэр, хувийн машин, байгууллагаас ханган олгосон албаны машин, бусад байгууллагын барилга байгууламж болон нийтийн эзэмшлийн талбай орж болно. |
| 3.4 Эрсдэл | Тодорхой бус байдлын үр нөлөө<br>Тайлбар 1: Энэхүү баримт бичигт, “эрсдэл ” гэдэг үг нь өөрөөр заагаагүй тохиолдолд КОВИД -19 (3.6)-ийн эрсдэлийг хэлнэ. |
| 3.5 Цар тахал | Дэлхийн хэмжээнд тархаж буй өвчлөл |
| 3.6 КОВИД -19 | Шинэ төрлийн коронавируст халдварт өвчин, SARS-CoV-2 бөгөөд 2019 онд анхлан илэрч тархсан. |

| | |
|---|---|
| **3.7 Аюултай тохиолдол** | Ажлаас үүдэлтэйгээр гэмтэл бэртэл, эсвэл эрүүл мэндэд муугаар нөлөөлж болзошгүй үр дагавар<br>Тайлбар 1: Энэхүү баримт бичигт, "гэмтэл бэртэл болон эрүүл мэнд, өвчлөл гэдэг нь КОВИД -19 (3.6)-ийн шууд халдвар эсвэл, түүнээс шалтгаалсан биеийн болон сэтгэл санааы өвчлөлийг хэлнэ. |
| **3.8 Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл (НБХХ)** | Эрүүл мэнд, аюулгүй байдлыг нэг буюу хэд хэдэн аюулаас хамгаалах зорилгоор хувь хүний өмсөж зүүх зориулалттай төхөөрөмж, хэрэгсэл<br>Тайлбар 1: НБХХ гэдэгт комбинзон, бээлий, амьсгалын аппарат, хамгаалалтын нүдний шил, дуулга, битүү шил орох бөгөөд, үүгээр хязгаарлагдахгүй.<br>Тайлбар 2: Ерөнхийдөө маскийг НБХХ гэж авч үздэггүй ч тэдгээр нь дамжих халдвар тархалтыг хянах нийгмийн эрүүл мэндийн үндсэн зорилгоос гадна хэрэглэгчийн тодорхой хэмжээний хамгаалалт болж чадна. (нүүрний хаалт 3.9)<br>Тайлбар 3: Олон оронд НБХХ-ийн үндэсний стандартыг гаргаж, дүрэм журамд нийцсэн байхыг шаарддаг. |
| **3.9 Нүүрний хаалт** | Ам, хамар, эрүүг бүрхсэн нүүрний хаалт<br>Тэмдэглэл 1: Нүүрний хаалтыг гадуурхи маск, эрүүл ахуйн маск, хаалт гэх мэтээр төрөл бүрээр нэрлэдэг.<br>Тэмдэглэл 2: Нүүрний хаалтыг энэхүү баримт бичигт НБХХ (3.8) эсвэл эмнэлэг эмчилгээний төхөөрөмж гэж тооцохгүй болно. |
| **3.10 Сайн сайхан байдал** | Гүйцэтгэж буй ажил үүрэгтэй холбоотойгоор ажилтаны (3.2) бие бялдар, оюун ухаан, мэдлэг, сэтгэхүйн хүлээлт<br>Тэмдэглэл 1: Сайн сайхан байдал нь ажлаас гадна, тухайн хүний амьдралын чанарт хувь нэмэр оруулна.<br>Тэмдэглэл 2: Сайн сайхан байдал нь ажлын зохион байгуулалт, ажлын байран дахь нийгмийн хүчин зүйлс, ажлын орчин, тоног төхөөрөмж, аюултай ажил гүйцэтгэх зэрэг ажил гүйцэтгэх бүхий л асуудалтай холбоотой. |

| | |
|---|---|
| 3.11 Нийтийн эзэмшил | Нэгээс дээш хүн цуглarах зай талбай, барилга байгууламж<br>Жишээ нь:<br>Хоолны газар, лифт/цахилгаан шат, энгийн шат, хүлээн авах хэсэг, хурлын өрөө, шашин, зан үйлийн газар, бие засах газар, цэцэрлэгт хүрээлэн, галын гарц, гал тогоо, биеийн тамир, бялдаржуулах газрууд, агуулах, угаалгын газар гэх мэт. |

## 4. Төлөвлөлт ба эрсдэлийн үнэлгээ




### 4.1 Байгууллага ба түүний төлөв байдлыг ойлгох нь

4.1.1 Байгууллагаас зохион байгуулж буй ажил үүрэг, үйл ажиллагаанд өртөж болзошгүй ажилтнууд болон бусад хүмүүст (жишээлбэл, зочид, худалдан авагчид, хэрэглэгчид, олон нийт) учрах тодорхой эрсдэлийг ойлгохын тулд байгууллага дараах зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй:

*1 COVID-19 цар тахлын үед хүмүүсийн аюулгүй ажиллах чадварт юу нөлөөлж болох вэ?*

*2 Ажилтай холбоотой эрүүл мэнд, аюулгүй байдал, ажлын бэлэн байдалд учрах эрсдэлийг арилгахын тулд байгууллагын үйл ажиллагаа нь хэрхэн өөрчлөгдөх ёстой вэ.*

КОВИД-19 -тэй холбоотой эрсдэлийг үнэлэхээс өмнө байгууллага нь ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлж болох гадаад, дотоод тодорхой асуудлууд, цар тахлын улмаас эдгээр асуудлууд хэрхэн өөрчлөгдөж, нөлөөлж байгааг анхаарч үзэх хэрэгтэй. Байгууллага нь эрсдэлийг үнэлэх, үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэх, өөрчлөх төлөвлөгөө гаргахдаа эдгээр асуудлыг харгалзан үзэж, эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж байх ёстой.

4.1.2 Байгууллагын гадаад асуудал




4.1.3 Байгууллагын дотоод асуудал




## 4.2 Манлайлал ба ажилтны оролцоо

4.2.1 Ажилтай холбоотой COVID-19-ээс үүсэх эрсдэлийг үр дүнтэй удирдахад туслахын тулд байгууллага дараахь зүйлийг хийх ёстой.

- Хариуцлага, аюулгүй ажиллагааны дадал зуршилд манлайлал, тууштай байдлаа харуулах;
- Дотоод бодлого, дүрэм журмын талаар байнгын харилцаатай байж, тууштай дагаж мөрдөх;

*Тэмдэглэл: Орон нутгийн, бүс нутгийн эсвэл үндэсний удирдамжийг хэрэгжүүлж болно.*

- КОВИД-19 -ийн сэжигтэй, батлагдсан тохиолдлыг мэдээлэх, удирдахдаа ил тод байдлыг хадгалах хэдий ч хувь хүний мэдээлэл, эрүүл мэндийн мэдээллийг нууцлах (5-р зүйлийг үзнэ үү);

- Хангалттай нөөцөөр хангах (8-р зүйлийг үзнэ үү), цаг үеийн нөхцөл байдалд тохируулан ажиллагсдыг нөөцөөр үр дүнтэй хангах;
- Ажилтай холбоотой эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдалд нөлөөлөх шийдвэр гаргахад ажилтан, ажиллагсдын төлөөлөл байгаа тохиолдолд тэдэнтэй зөвлөлдөх, оролцоог нь дэмжих;
- Үйл ажиллагааны хязгаарлалтын улмаас ажиллах боломжгүй, эсвэл өөрийгөө тусгаарлах, хорио цээрийн дэглэмд, хөл хориoнд орох шаардлагатай ажилтнуудад учирч буй санхүүгийн нөлөөллийн талаар тодорхой бодлого боловсруулж өгөх;
- Үйл ажиллагааны хязгаарлалтын улмаас ажиллах боломжгүй, эсвэл өөрийгөө тусгаарлах, хорио цээрийн дэглэм, хөл хориoнд орсон шаардлагатай ажилтнуудад зохих дэмжлэг үзүүлэх, үүнд: амралт, чөлөө олгох, боломжтой бол цалинтай чөлөө олгох (Ажиллагсад цалин хөлсөнд санаа зовж үүний улмаас ажлаа хийж буй байдлыг багасгах);
- Ажилтнууд болон бусад холбогдох сонирхогч талууд аюултай тохиолдлын талаар хэрхэн мэдээлэх эсвэл асуудал дэвшүүлэх, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэж, хариу арга хэмжээ авах талаархи асуудлыг тодорхой болгох, мэдээлэх;
- Болзошгүй өвчлөл, аюултай тохиолдлын талаар мэдээлэх, ажилтнууд өөрсдийгөө өвчилсөн гэж үзэн ажлын байрандаа ирээгүй, эсвэл тухайн шалтгааны улмаас ажлын байрнаас явсан тохиолдолд ажилтнуудад зөрчлийн арга хэмжээ авахаас хамгаалах;
- КОВИД-19 -тэй холбоотой эрсдэлийг удирдах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ байгууллагын бүх хэсгүүдийн уялдаа холбоог хангах;
- Шаардлагатай бол КОВИД -19-тэй холбоотой эрсдэлийг удирдах талаар мэргэжлийн хүмүүс, байгууллагаас зөвлөгөө, мэдээлэл авах.

4.2.2 Байгууллага нь үйл ажиллагаанд нь нөлөөлж болзошгүй өөрийн ажилтнууд болон бусад сонирхогч талуудаас гадна үйлчлүүлэгч, үйлчилгээ авагч, олон нийт зэрэгт анхаарал халамж тавих үүрэгтэй. Байгууллага зөвхөн өөрийн ажилтан, сонирхогч талуудаас гадна олон нийтийг оруулж тооцоолсноор цар тахлын үеэр ажилтай холбоотой эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдалд учрах эрсдэлийг илүү сайн тоймлон, өргөн цар хүрээтэй харах боломжтой. Ажилтан, ажиллагсдын төлөөлөлтэй идэвхтэй, байнгын холбоотой байх нь КОВИД -19-тэй холбоотой эрсдэлийг удирдахад илүү сайн үр дүнд хүргэх болно.

Байгууллага нь:

- КОВИД -19-тэй холбоотой эрсдэлийг үнэлэх, тэдгээрийг хэрхэн удирдах талаар шийдвэр гаргахад оролцоог дэмжиж, ажилтан, ажилтнуудын төлөөллийг оролцуулах;
- Ажиллагсад болон бусад холбогдох сонирхогч талуудтай (жишээлбэл, олон нийт, үйлчлүүлэгчид, ханган нийлүүлэгчид, зочид, оюутнууд, хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид, зохицуулагч агентлагууд, үйлдвэрчний эвлэлүүд) байгууллага нь КОВИД-19 -ийн эрсдэлийг хэрхэн удирдаж байгааг мэдээлэх (харилцаа холбоо, мэдээлэл түгээлт нь ямар ч тохиромжтой аргаар байж болно, 9-р зүйлийг үзнэ үү);
- Ажилтнууд болон бусад сонирхогч талуудад ажилтай холбоотой эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдлыг удирдан зохион байгуулах талаар (жишээ нь видео уулзалт, мэдээллийн хэрэгсэл, онлайн судалгаа, имэйлээр дамжуулан) үйл ажиллагааны талаар санал хүсэлтээ илэрхийлэх нэг буюу хэд хэдэн арга замыг нэвтрүүлэх;
- Ажилтнууд болон бусад сонирхогч талуудын тавьсан асуудлыг шийдвэрлэхэд цаг тухайд нь, зохих арга хэмжээг авч, эргэн хариу мэдэгдэх.

### 4.3 Ерөнхий төлөвлөлт

4.3 Байгууллагын шийдвэр гаргагчид болон ажилтнуудын төлөөлөл нь ажилтнуудын туршлага, ажлын онцлогийг тусган үүнд үйл ажиллагаа явуулж буй газарт ажиллах хүчний бүрэн олон янз байдал, тухайлбал

хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд, эмэгтэйчүүд, төрөл бүрийн үндэс угсаа, ёс заншилтай ажиллагсад, ажилтнуудын насны бүлэг зэргийг харгалзан үзэх шаардлагатай.

4.3.1 Төлөвлөлт нь байгууллагаас ажилтай холбоотой эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдалд нөлөөлж болох цар тахлын улмаас үүсэх эрсдэлийг олж тогтоох, эрсдэлийг эрэмбэлэх боломжийг олгодог.

КОВИД -19-тэй холбоотой эрсдэлийг бүхэлд нь арилгах боломжгүй боловч төлөвлөлтийг зөв хийснээр ажиллагсдад учрах эрсдэлийг эрэмбэлэх, тэдгээрийг бууруулахад ач холбогдолтой.

Төлөвлөлт хийхдээ байгууллага 4.1-д тодорхойлсон асуудлуудыг харгалзан харгалзан үзнэ. Үүнд:

- Ажлын зохион байгуулалт, ажил явагдаж байгаа газрыг бодитоор өөрчлөх;
- Ажиллагсдын хоорондын харилцан үйлчлэл, нөлөөлөл;
- Ажилтнууд болон бусад хүмүүс, түүний дотор зочид, үйлчлүүлэгчид, олон нийтийн хоорондын харилцан үйлчлэл;
- Нууцлалын хэрэгцээг хүндэтгэх хэдий ч халдвар гарсан тохиолдолд, эсвэл гарахаас урьдчилан сэргийлж, мөшгилт хийх, холбоо барих зорилгоор тодорхой хүмүүс (жишээлбэл, ээлжийн ажилтнууд, уушийн газар, ресторaны үйлчлүүлэгчид, биеийн тамирын заал дахь үйлчлүүлэгчид) -тэй холбоо барих мэдээллийг үнэн зөв, бүрэн хөтлөх;
- Нийтийн эзэмшлийн талбай, дундын тоног төхөөрөмжийг аюулгүй ашиглах;
- Цар тахлын сэтгэлзүйн эрүүл мэнд, сайн сайхан байдалд үзүүлэх нөлөө (6-р зүйлийг үзнэ үү).

4.3.2 Байгууллага нь КОВИД-19 -тэй холбоотой эрсдэлийг тодорхойлох, шийдвэрлэхэд системтэй хандаж, дараахь ажлуудыг хийх ёстой.

- Гэрээс гүйцэтгэх боломжтой ажил;
- Гэрээс гүйцэтгэх боломжгүй, гэхдээ ажлын байран дахь аюулгүйн хоорондын зайг баримтлах ажиллах боломжтой гэдэг нь практикаар нотлогдсон;
- Гэрээс гүйцэтгэх боломжгүй, ажлын байран дахь аюулгүйн хоорондын зайг баримтлах, дагаж мөрдөх боломжгүй байх.

Олон байгууллагуудын хувьд КОВИД-19 -ийн ажилтай холбоотой эрсдэлийг бууруулах хамгийн сайн арга бол ажилтнуудыг гэрээс ажиллах боломжийг олгох, дэмжих явдал юм. Байгууллага нь ажилтнуудаа бусад хүмүүстэй харьцах харьцааг багасгах замаар сайжруулсан хамгаалалтыг бий болгохын тулд биеэр ажил үүрэг гүйцэтгэж буй ажлын байран дахь ажилтнуудын тоог багасгах хэрэгтэй. Байгууллага нь ажлын байранд биеэр ажил үүрэг гүйцэтгэх ажиллагсдын тоог тодорхойлохдоо үйлчилгээ авагч, үйлчлүүлэгч, худалдан авагч, мөн ажил гүйцэтгэж буй ажилтнуудын хэрэгцээг харгалзан үзэх ёстой.

Байгууллага нь гэрээс болон ажлын байрнаас гадуур ажиллаж байгаа ажилтнуудын бие бялдар, сэтгэлзүйн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хамгаалах нэмэлт дэмжлэгийн арга хэмжээг хэрэгжүүлж байх ёстой. Ажилтны гэр нь ажлаа гэрээс гүйцэтгэхэд тохиромжгүй, эсвэл гэрээр ажиллах нь тэдний сэтгэлзүйн эрүүл мэнд, сайн сайхан байдалд сөрөг нөлөө үзүүлдэг бол тэдгээр ажилтнуудыг ажлын байранд аюулгүй ажиллах боломжтой эсэхийг авч үзэх хэрэгтэй.

Гэрээс хийх боломжгүй, хүн хоорондын аюулгүйн зайг дагаж мөрдөх боломжгүй, зайлшгүй ажиллах үйл ажиллагааг эрсдэлийг бууруулах нэмэлт хяналтын арга хэмжээг хэрэгжүүлсэн тохиолдолд л хийгдэх ёстой.

4.3.3 Байгууллага КОВИД -19-тэй холбоотой эрсдэлийг шийдвэрлэхээр төлөвлөхдөө одоогийн ХЭМАБ-н эрсдэл, тэдгээрийг удирдах хэрэгжиж буй арга хэмжээг харгалзан үзнэ. Байгууллага нь:

- Ажлын үйл явцад гарсан аливаа өөрчлөлтийг харгалзан одоо байгаа ХЭМАБ-н хэмжүүр, хяналтыг шинэчлэх, тохируулах шаардлагатай эсэхийг үнэлэх;

- COVID-19-тэй холбоотой эрсдэлийг удирдах аюулгүй байдлын нэмэлт арга хэмжээг хэрэгжүүлж нэвтрүүлж болох ХЭМАБ-н шинэ эрсдэлүүд (жишээлбэл, галын аюулгүй байдлын зохицуулалтад үзүүлэх нөлөө) болон бусад эрсдэлийг (жишээлбэл, харуул хамгаалалт, аюулгүй байдлын эрсдэл) авч үзэх (аюулгүй байдал, харуул хамгаалалтын талаар хавсралт А-г үзнэ үү) ;
- Шинэ эрсдэлийг арилгах арга хэмжээг төлөвлөх;
- Үйл ажиллагааны тасалдлыг багасгахын тулд орон нутгийн, бүс нутгийн, үндэсний болон олон улсын түвшинд хамааралгүй өөрсдийн дотоодын богино хугацаанд хязгаарлалтын өөрчлөлтийг төлөвлөх (4.8-г үзнэ үү).

### 4.4 Ажлын байр




### 4.4.1 Биеэр гүйцэтгэх ажлын байр

4.4.1.1 Байгууллага нь бүх ажлын байруудыг (сайт, ажлын байр, барилга байгууламж болон гадуур ажил гүйцэтгэх ажлын байр орно.) болон эдгээр ажлын байруудад ашиглагдаж буй барилга байгууламж нь ашиглахад аюулгүй, цэвэр байлгах ёстой.

Үйл ажиллагааг аюулгүй эхлүүлэхэд бэлтгэхийн тулд байгууллага дор хаяж дараахь зүйлийг хийх ёстой. Үүнд:

**Биеэр гүйцэтгэх ажлын байранд тавигдах шаардлага**

- Хаагдсан буюу хэсэгчлэн үйл ажиллагаа явуулж байсан бүх байр, талбай, хэсэгчилсэн талбайг үнэлэх, үнэлгээ хийх;
- Халдвар тарааж болзошгүй хүмүүсийг ажлын байранд нэвтрэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
- Тоног төхөөрөмж, системд засвар үйлчилгээг хийх, шалгах тохируулах
- Эрүүл мэндэд узүүлэх бусад эрсдэлийг нэвтрүүлэхгүйн тулд устай холбоотой өвчинтэй холбоотой эрсдэлийг үнэлэх, хянах, ялангуяа ус дамжуулах дэд бүтцийн системийг тодорхой хугацаанд ашиглаагүй эсвэл ашиглалтыг бууруулсан бол;
- Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгалын давтамж хуваарийг ойртуулах, сайжруулах (жишээлбэл, цэвэрлэгээ хийх ажиллагсдын ажлын цаг, эсвэл ажилтны тоог нэмэгдүүлэх, бусад ажилтнуудыг өөрсдийн ажлын байр, тоног төхөөрөмжийг тогтмол цэвэрлэж, ариутгахыг уриалах);
- Ахуйн ариун цэврийн байгууламжийг сайжруулах, үүнд боломжтой бол гар угаах газруудыг нэмэгдүүлэх, боломжгүй бол гар ариутгах цэгүүдийг олшруулах (ажил, завсарлагаанд ашигладаг гаднах талбайг оруулаад), эдгээр байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй ажиллагсдад тохиромжтой хүртээмжтэй байлгах;
- Сайт, ажлын байр байгууламж, түрээсийн байр зэрэг хамтран эзэмшдэг, ажилладаг бусад гэрээт компаниуд, сонирхогч талуудтай ердийн үйл ажиллагаа болон онцгой байдлын төлөвлөгөөг хамтран гаргаж дагаж мөрдөн ажиллах

4.4.1.2 Байгууллага нь дараахь зүйлийг багтаасан арга хэмжээ авна. (үүгээр хязгаарлагдахгүй) Үүнд:

- Ажлын байр, тоног төхөөрөмжид их цэвэрлэгээ хийх, халдваргүйжүүлэх;

- Цорго, шүршүүр болон бусад усны эх үүсвэрийг КОВИД -19-ийн эсрэг хэрэглэх албан ёсны шаардлага хангасан бүтээгдэхүүнээр ариутгаж, хэрэглэхээс өмнө усыг урсган гадагшлуулах;
- Агааржуулалтын системээр (зохих шүүлтүүр, ашиглалтын хугацааг оруулан) болон гаднаас орж ирэх агаар солилцоог хангалттай байлгах, доторхи агааржуулалтын системийг унтрааж, хаалга, цонхыг аль болох нээлттэй байлгах;
- Ариун цэврийн байгууламжийг аюулгүй ашиглахад дөхөм болохуйц байлгах (12.6.2-ыг үзнэ үү);
- Ердийнхөөс удаан хугацаагаар ашиглагдаагүй мэргэжлийн тоног төхөөрөмжийг дахин эхлүүлэх, турших;
- Галын аюулгүй байдлын систем, үүнд аваарын гэрэлтүүлэг, дохиолол гэх мэт батерейгаар ажилладаг төхөөрөмжүүдийг шалгах, турших;
- Хүн хоорондын аюулгүйн зайг харуулсан тэмдэг тэмдэглэгээг харааны бэрхшээлтэй хүмүүст харагдахуйц энгийн, ойлгомжтой, том хэмжээтэйгээр шал, ба / эсвэл хананд байрлуулах;
- Хүн хоорондын аюулгүйн зайг зохих хэмжээнд хэрэгжүүлэх, зайг тусгаарласан хаалт, хашилт хийх , үүнийг хийхдээ ХЭМАБ-ын эрсдэлийг тооцоолох, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сөргөөр нөлөөлөхгүйгээр хийх;
- Аль ч ажлын байранд ажиллах хүмүүсийн тоог хязгаарлах, тоог заасан ажлын бүсийг бий болгох (12.5-ыг үзнэ үү);
- Дундын тоног төхөөрөмж ашиглаж буй хүмүүсийн тоог зааж өгч, зориулалтын дундын тоног төхөөрөмжид хуваарилах замаар хязгаарлах;
- Ажилтнуудыг ажлын цагаар гадаргуу, тоног төхөөрөмжийг арчиж цэвэрлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн цэг байгуулах;
- Хүн хоорондын зайг мөрдөхийн тулд хөдөлгөөнт төхөөрөмж, ширээ, ажлын байрыг өөрчлөн байгуулах;
- Хаалганы бариулд хүрэхийг багасгах үүднээс хаалгыг шинэчлэх, автоматжуулах (галын аюулгүйн гарц, аюулгүй байдал, хувийн нууцад шаардагдах хаалгуудаас бусад);

- Ажлын байранд аюулгүй нэвтрэх, гарах үйл явцыг бий болгох;
- Коридор, шат, бусад нийтлэг газруудад нэг чигийн хөдөлгөөний систем бий болгох, тэмдэг тэмдэглэгээг, шал, хананд байршуулах, боломжгүй тохиолдолд эрсдэлийг бууруулах бусад арга хэмжээ авах;
- Цахилгаан шат/лифт ашиглах аюулгүй арга, түүний доторхи хүмүүсийн хязгаарлалтын тоог тодорхойлох, цахилгаан шат/лифтний дотор болон гадна талд аюулгүйн зааврыг байршуулах;
- Боломжтой бол ажилтнуудад байнгын ажил, уулзалт, завсарлагаанд ашиглах гадна нэмэлт зай, талбайг гаргаж өгөх.

### 4.4.2 Гэрээс ажиллах

4.4.2.1 Байгууллага нь цар тахалтай холбоотой эрсдэлийг удирдах хамгийн үр дүнтэй аргуудын нэг нь ажилтнуудыг хамгийн боломжит хэмжээгээр гэрээс нь ажиллуулах боломжийг бүрдүүлэх ёстой. Байгууллага нь тогтмол ажлын байранд ажилладаг хүмүүстэй адил гэрээр ажиллаж байгаа ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. Байгууллага нь ажилтнуудаа гэрээс ажиллахад тулгардаг саадыг арилгах бүх практик арга хэмжээг авах ёстой.

Байгууллага нь ямар ажилтнуудын гэрээс ажиллуулах эсэхээ тодорхойлохдоо дараахь асуултыг асууна.

*Та өөрийн ажил үүргээ гэрээсээ үр дүнтэй гүйцэтгэж чадах уу?*

*Та биеэр гүйцэтгэх ажлын байрандаа ажиллахыг хүсч байна уу?*

*Та КОВИД -19-т өртөхгүйгээр биеэр гүйцэтгэх шаардлагатай ажлыг хийхдээ ажлын байранд аюулгүй ирж буцах боломжтой юу?*

4.4.2.2 Байгууллага нь дараахь хүчин зүйлсийг харгалзан гэрээсээ ажиллахтай холбоотой эрсдэлийг болон түүнийг шийдвэрлэхэд шаардлагатай үйл ажиллагааг системтэйгээр үнэлэхийн тулд ажилтантай зөвлөлдөх ёстой.

- Ажилтны гэр бүлийн нөхцөл байдал (жишээлбэл, хүүхэд асрах эсвэл бусад гэр бүлийн гишүүдийг асрамжлах, гэр бүлийн хүчирхийлэл, КОВИД -19-ийн халдвар авах эсвэл КОВИД -19-ээс хүнд өвчин тусах эрсдэл өндөртэй гэж үзсэн гэр бүлийн гишүүд);
- Гэр, байшин, орон сууцны тохиромжтой байдал (жишээлбэл, хэмжээ, бусадтай хуваалцаж буй зай талбай, дуу чимээний түвшин, тохиромжтой гэрэлтүүлэг, эргономикийн асуудлууд);
- Ажилтан нь холбогдох систем, мэдээлэлд нэвтрэх боломж (жишээлбэл, имэйл, дундын шэйр, мэдээллийн сан, холбогдох системийн сайжруулсан аюулгүй байдал, гэрээс аюулгүй ажиллах заавар);
- Мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, програм хангамжийг ашиглах хэрэгцээ, түүнд дэмжлэг үзүүлэх (жишээлбэл, онлайн хурлын хэрэгслүүд);
- Ажилтан ажлын байран дээрээ ашигладаг тоног төхөөрөмжийг түр хугацаагаар гэр лүүгээ авч явах эсвэл нэмэлт тоног төхөөрөмжөөр хангах боломжийг олгох (жишээлбэл, компьютер, компьютерийн дэлгэц, гар, хулгана, эргономикийн хувьд тохиромжтой сандал, хөлийн тулгуур, гэрэл, принтер, чихэвч) ;
- Эргономикийн хувьд тохиромжтой гэр доторхи ажлын байрыг бий болгох талаар зааварчилгаа өгөх шаардлагатай (жишээлбэл, Тохиромжтой байршил, тогтмол хөдөлгөөнийг дэмжих);
- Сэтгэлзүйн эрсдэл (6-р зүйлийг үзнэ үү);
- Хувийн болон байшингийн даатгал, татварын өр төлбөрт үзүүлэх нөлөөлөл.

Байгууллага нь ажилтан эсвэл ажилтны гэр бүлийн аль нэг гишүүн нь КОВИД -19-т өртсөн тохиолдолд өөрийгөө тусгаарлах, хорио цээр тогтоох шаардлагатай ямар арга хэмжээг авах талаар ажилтнуудад зааварчилгаа өгөх ёстой.

### 4.4.3 Бусдын гэрээс ажиллах

4.4.3.1 Хэрэв тухайн гэр бүлийн хэн нэгэнд КОВИД-19 -ийн шинж тэмдэг илэрвэл (эсвэл өөрөө тусгаарлагдсан, хорио цээрийн дэглэмтэй бол) эсвэл КОВИД-19 халдвартай, эсвэл КОВИД-19 тусах эрсдэл өндөртэй гэж үзвэл ажилтнууд бусад хүмүүсийн гэрээс доорхи тохиолдлоос бусад нөхцөлд ажил, хөдөлмөр эрхлэх ёсгүй. Үүнд:

- Зайлшгүй шаардлагатай эрүүл мэнд, хувийн тусламж үйлчилгээ үзүүлэх (жишээлбэл, эмнэлгийн болон нийгмийн халамжийн ажилтнууд);
- Аюулгүй байдал, болон түүнд шууд учрах эрсдэлийг арилгах (жишээлбэл, сантехникч, барилга засварын ажилтан, цахилгаанчин, хийн инженерийн холбоотой яаралтай засвар үйлчилгээ);
- Нийгмийн эмх замбараагүй байдал, нийгмийн эмзэг байдлыг хамгаалах бусад арга хэмжээг хүмүүс, гэр бүлийн гэрт нь шийдвэрлэх.

4.4.3.2 Байгууллага нь ажилтнуудаа бусдын гэрээс ажиллуулах зайлшгүй шаардлагатай тулгарсан бол дараахь зүйлийг хийх ёстой.

- Өрхийн хэн нэгэн нь КОВИД -19-ийн шинж тэмдэгтэй эсэх, өөрийгөө тусгаарлаж байгаа эсэх, хорио цээрийн дэглэмд хамрагдсан, эсвэл өөрсдийгөө КОВИД -19-ийн эрсдэл өндөртэй хүмүүсээс хамгаалахын тулд гэртээ тусгаарлахыг зөвлөсөн эсэхийг шалгах;
- Ажлыг дижитал болон зайнаас ажиллах хувилбараар (жишээлбэл, видео эсвэл утасны зөвлөгөө) гүйцэтгэж болох эсэхийг авч үзэх;
- Ажил эхлэхээс өмнө тухайн айл өрхтэй холбоо тогтоож, ажил хэрхэн явагдах талаар болон эрсдэлийг багасгах ерөнхий дадал туршлагын талаар ярилцаж тохиролцох (жишээлбэл, байшин руу хүн хоорондын зайг баримтлан нэвтрэх, айлд орохоосоо өмнө гараа ариутгах, гадагшаа гарахаасаа өмнө гараа угаах, гэрт байхдаа хүн хоорондын зайг баримтлах, хаалганы бариултай хүрэлцэх харьцааг багасгахын тулд дотор хаалгыг онгорхой орхих);

- Нийтийн тээврийн хэрэгслээр зорчих, ашиглах явдлыг хамгийн бага байлгахын тулд ажилчдыг аль болох орон нутгийнхаа айлуудад ажиллуулах;
- Ажилтнуудад зохих хэмжээний НБХХ, маск эсвэл нүүрний хаалт, гар ариутгагч, цэвэрлэгээ, ариутгалын материалаар боломжийн хирээр хангах;
- Ажлын байранд давтамжтай зочлох шаардлагатай эсвэл ажил үргэлжилж байвал (жишээлбэл асран хамгаалагч, цэвэрлэгч) ажлын төрөл, ажил гүйцэтгэх хэмжээг харгалзан 1 ажилтан, хосолж ажиллах ажилтнууд, цомхон багаар хуваарилах, 1 дор амьдардаг хүмүүс байвал тэдгээрийг 1 багт хуваарилах гэх мэт арга хэмжээг авна.

4.4.3.3 Байгууллага нь КОВИД-19 -өөр өвчилсөн, КОВИД-19 -тэй хүнтэй ойрын хавьтал болсноос шалтгаалж, ажилтан нь тусгаарлалтанд орсон, хөл хорионд орсон тохиололд шаардлагатай нөхцөл байдлыг зохицуулах тодорхой бодлого, үйл явцыг тогтоож, мэдээлэх ёстой.

### 4.4.4 Олон байршилд эсвэл явуулын ажлын байранд ажиллах

Байгууллага нь гэртээ эсвэл тогтсон ажлын байранд гүйцэтгэх боломжгүй ажилтнуудад (жишээлбэл, жолооч, нийгмийн болон хувийн асрамжийн үйлчилгээ эрхлэгчид, үйлчлэгч, шуудангийн ажилтнууд, хүргэлтийн ажилтнууд, замын хөдөлгөөний хянагч, цагдаа, засвар, үйлчилгээ хариуцсан ажилтнууд) дэмжлэг үзүүлж байх ёстой. Тэдэнд аюулгүй ажиллах, аялах, бусад хүмүүстэй харилцах замаар өвчин дамжихаас зайлсхийх заавар, хангалттай нөөцийг бүрдүүлж өгөх ёстой.

Байгууллага нь явуулын үүрэг гүйцэтгэж буй ажилнтуудыг бүрэн мэдээллээр хангаж, янз бүрийн нөхцөл байдалд зохих ёсоор ажиллахын тулд өөрсдийн болгоомжтой байдалд итгэлтэй байхын тулд ажилтан болон ажилтнуудын төлөөлөлтэй зөвлөлдөх ёстой. Байгууллага нь удирдамж өгч, хөдөлгөөнт үүрэгт ажилтнуудыг дараахь байдлаар зөвлөн дэмжих ёстой.

- Хүн хоорондын аюулгүйн зай, эрүүл ахуйн талаархи заавры дагаж мөрдөх (10-р зүйл);

- Хүн хоорондын аюулгүйн зайг баримтлах боломжгүй эсвэл бусад хүмүүс зай барихгүй байгаа нөхцөлд хэрхэн яаж ажиллах зааврыг дагаж мөрдөх;
- Бусад байгууллагууд аюулгүй байдал, харуул хамгаалалт болон бусад шалтгаанаар НБХХ, маск, нүүрний хаалтыг авах шаардлагатай бол хэрхэн ажиллах талаар зааврыг дагаж мөрдөх;
- Хангалттай хэмжээний НБХХ, маск, нүүрний хаалт, гар ариутгагч, цэвэрлэгээ, ариутгалын материалыг авах боломжоор хангах;
- Нийтийн бие засах газар зэргийг хэрхэн зөв, аюулгүй ашиглах, хоол хүнс, уух зүйлсийг хэрхэн аюулгүй худалдан авах, хэрэглэх заавstatic дагаж мөрдөх;
- Шаардлагатай бол ажлын явцад очсон газруудынхаа талаар холбоо барих мөшгих ажиллагааг дэмжих баримтжуулсан мэдээллийг хадгалах;
- Ажилтан эсвэл бусад холбогдох этгээдээс КОВИД-19 илэрсэн эсвэл сэжигтэй тохиолдолд үр дүнтэй холбоо барих, мөшгихөд тус нэмэр болохын тулд боломжтой бол удаан хугацааны ажлын ажиллагаа эсвэл ойр дотно харилцаатай хүмүүсийнхээ мэдээллийг хадгалах (хувийн мэдээллийг хамгийн багадаа 14 хоног хадгалах, эсвэл албан ёсны удирдамжаар тодорхойлогдсон байна).

**4.5 Үүрэг хариуцлага**

4.5.1 Байгууллага нь ажилтнуудын үүрэг, үйл ажиллагаа, хаана ажиллах ёстойг үнэлэхдээ дараахь зүйлсийг харгалзан үзнэ.

- КОВИД -19-тэй халдвар авах эсвэл түүнээс  хүнд өвчин тусах эрсдэл өндөртэй ажилтнууд;
- КОВИД-19-өөр өвчлөх, эсвэл түүнээс хүнд өвчин тусах эрсдэл өндөртэй гэж тооцогдох хүнийг асран халамжлах;
- КОВИД -19-өөр өвчлөх, эсвэл түүнээс хүнд өвчин тусах эрсдэл өндөртэй гэж тооцогддог хүнтэй хамт амьдардаг, нэг гэр бүл байх;

- Хөгжлийн бэрхшээлийн улмаас эсвэл хувь хүний бусад нөхцөл байдлаас шалтгаалан үндэслэлтэй нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй, шаардах эсвэл шаардлагатай ажилтнууд (жишээлбэл, аутизм, жирэмсэн, хүн амын цөөнхийн бүлгүүд (арьс өнгө, этник бүлгүүд гэх мэт);
- Сэтгэлзүйн эрүүл мэнд, сайн сайхан байдлаа хамгаалахад нэмэлт дэмжлэг үзүүлэх.

Байгууллага нь гэрээсээ үр дүнтэй ажиллах чадвартай ажилтнуудыг гэрээс нь ажиллуулахыг дэмжих ёстой. Үүнийг үр дүнтэй болгохын тулд байгууллага 4.4.2-т гарсан асуудлуудыг харгалзан тодорхойлсон арга хэмжээ авч, дэмжлэг үзүүлэх, сайн сайхан байдалд хяналт тавих, тухайн ажилтныг бусад гэрээс ажиллаж буй ажилтнуудтай, сайт, үйлдвэрлэлийн бүсэд ажиллаж байгаа хүмүүстэй холбож өгөх зорилгоор тогтмол онлайн эсвэл утсаар уулзалт зохион байгуулж байх ёстой.

Байгууллага нь гэртээ ажиллаж буй ажилтнуудаас ямар хүлээлттэй байгаа талаар тодорхой мэдээлэл өгч, ажилтнуудын хэрэгцээг аль болох хангах боломжтой байх ёстой.

4.5.2 Биеэр гүйцэтгэх ажлын байранд байх шаардлагатай ажилтнуудын хувьд байгууллага дараах зүйлийг хийнэ.

- Үйл ажиллагааны тасралтгүй байдал, байгууламжийн аюулгүйн менежмент эсвэл зохицуулалтын ажиллагаа нь чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд эдгээр ажлыг гэрээсээ гүйцэтгэх боломжгүй байдаг. Эдгээр ажлуудыг эрэмбэлэн тодорхойлох.
- Гэрийн нөхцөлд ажиллах боломжгүй, эсвэл гэртээ мэргэжлийн тоног төхөөрөмж ашиглах боломжгүй, чухал үүрэг гүйцэтгэж буй ажилтнуудыг тодорхойлох;
- Аюулгүй, үр дүнтэй ажиллах шаардлагын дагуу биеэр гүйцэтгэх ажлын байранд шаардагдах ажилтнуудын хамгийн бага, боломжит тоог тодорхойлох;
- Үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулж байгааг тодорхойлох (жишээлбэл ажлын ээлж солихыг багасгах, ажилтнууд ээлжийн туршид нэг багц тоног төхөөрөмжөөр нэг төрлийн ажил хийхийг шаардах, ажлын уян хатан цагийг тохируулах).

Байгууллага нь КОВИД-19 -ийн халдвар авах, эсвэл түүнээс хүнд өвчнөөр өвдөх эрсдэл өндөртэй, гэрээсээ ажиллах боломжгүй ажилтнуудад биеэр гүйцэтгэх ажлын байранд ажиллахдаа маш болгоомжтойгоор үүрэг гүйцэтгэх зааварчлага өгөх ёстой.

Ийм үүрэг нь ажилтнуудад биеэр гүйцэтгэх ажлын байранд хэрхэн ажиллах талаарх зааврыг үргэлж дагаж мөрдөх боломжийг олгодог. Хэрэв КОВИД-19 -ийн халдвар авах эсвэл түүнээс хүнд өвчин тусах эрсдэл өндөртэй, мөн ажилтнууд хүн хоорондын аюулгүйн зайн зааврыг дагаж мөрдөж чадахгүй бол байгууллага нь ажилтан, ажилтнуудын төлөөлөлтэй зөвлөлдөж, аюулгүй байдлын нэмэлт арга хэмжээ, хяналтыг хэрэгжүүлэн эрсдэлийн түвшинг хүлээн зөвшөөрөгдөхүйц хэмжээнд бууруулан, түүнийг үнэлэн, ажиллах эсэх талаар зөвшилцөх хэрэгтэй.

Байгууллага нь КОВИД-19 -ийн аюулгүй байдлын арга хэмжээ, хяналтыг хэрэгжүүлэх, хадгалах, дээд удирдлагад асуудлыг тайлагнах үүрэгтэй тодорхой ажилтнуудын багийг (эсвэл жижиг байгууллагад ганц ажилтан) томилон ажиллуулна.

Хэрэв ажилтнуудад шинээр ажлын үүрэг, даалгавар хуваарилагдсан бол тухайн ажилтнуудад эдгээр үүргийг гүйцэтгэх чадвар олгохын тулд байгууллага хангалттай сургалт, дэмжлэг үзүүлэх ёстой.

Байгууллагын авч хэрэгжүүлж буй аюулгүй байдлын арга хэмжээ нь зарим ажилтнуудын бүлгүүдэд сөрөг нөлөөлөл үзүүлж болох эсэхэд хяналт тавих ёстой (жишээлбэл, асаргаа хийдэг ажилтнууд, шашны нарийн дэг баримталдаг ажилтнууд, хөгжлийн бэрхшээлтэй болон жирэмсэн ажилтнууд)

### 4.6 Үйл ажиллагаа

Хэрэв чухал арга хэмжээний үеэр хүн хоорондын аюулгүйн зайн удирдамжийг дагаж мөрдөх боломжгүй бол байгууллага нь ажилтнуудын хооронд болон ажлын байран дахь бусад хүмүүстэй харьцах замаар КОВИД -19-ийн халдвар дамжих эрсдэлийг бууруулахын тулд бүх арга хэмжээг авах ёстой.

Үйл ажиллагааг буцаан эхлэхээс өмнө байгууллага дараахь эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах хэрэгтэй.

- Ойрын хавьтал үүсгэх хүмүүсийн тоог хязгаарлахын тулд тогтмол хамтран ажиллах жижиг багууд эсвэл хослон ажиллах ажилтнуудыг бий болгох; хэрэв хэн нэгэн ажилтанд КОВИД -19-ийн шинж тэмдэг илэрвэл багийн бүх гишүүд өөрсдийгөө тусгаарлаж, албан ёсны удирдамжийн дагуу хорио цээр, хөл хорио тогтоовол баг, хосыг нэг нэгж гэж үзэх ёстой;
- Үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангах үүднээс ажлын заавлыг шинэчлэх (жишээлбэл, ажил гүйцэтгэх хугацааг аль болох богино байлгах, хүмүүсийг тусгаарлах самбар эсвэл хаалт ашиглах, өөд өөдөөс харан ажиллуулахын оронд хөндлөн эсвэл босоо тэнхлэгээр дараалан суулгаж, зогсоон ажиллуулах. );
- Ажил гүйцэтгэх үйл ажиллагааны хувьд хүн хоорондын аюулгүйн зайн удирдамжийг дагаж мөрдөх боломжгүй бүсүүдийг тогтоох;
- Ганцаараа аюулгүй ажиллах боломжтой ажилтнуудыг хүн хоорондын аюулгүйн зайг баримтлах үүднээс тусгаарлагдсан орон зайг ашиглан ажиллуулах;
- Эд зүйлстэй хүрэлцдэг, хүнээс хүнд дамжуулах дамжлага дээр ажил гүйцэтгэдэг (ажлын байрны мэдээлэл, сэлбэг хэрэгсэл, дээж, худалдаж авсан эд зүйл) ажилтнуудын бий болгох үйл ажиллагааг тодорхойлох, шууд хүрэлцэх үйл ажиллагааг аль болох багасгах (жишээлбэл, урсгуур, шилжүүлэх бүс гэх мэт);
- Зохих НБХХ-ээр хангах, түүнийг хэрхэн ашиглах талаар зааварчилгаа өгөх.

### 4.7 Онцгой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ

Байгууллага урьдчилан тооцоолох боломжтой онцгой нөхцөл байдалд бэлтгэж, одоогийн үйл ажиллагааны процессоо дахин үнэлж, шаардлагатай бол өөрчлөх хэрэгтэй. / Гамшгаас хамгаалах тухай хуулийн 2 дугаар бүлэг, 3-р бүлгийг цогцоор нь хэрэгжүүлж ажиллана. Коронавируст халдвар /КОВИД-19 /-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 5 дугаар зүйл. Үйл ажиллагаанд баримтлах зарчим /

Дараахь хүчин зүйлсийг анхааран авч үзнэ. Үүнд:

- Онцгой байдлын үйл явц (бусадтай ойр харьцах боломжийг хязгаарласан байдлаар хэрхэн багаар нь ажилтнуудаа аврах, ажилтнууд ба сонирхогч талуудыг цуглarax цэгт цуглуулахад биеэр ойртох боломжийг хязгаарлахын тулд багуудыг тус тусад нь цөөн хүнтэйгээр цуглуулах заавар гаргах); /Улсын онцгой комисс, Салбар яамдаас ирсэн чиглэлийн дагуу нүүлгэн шилжүүлэлт-татан авах төлөвлөгөө, түр хязгаарлалт буюу 0 зогсолтын үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж ажиллах. Дадлага сургууль хийж баталгаажуулах, тодотгол хийх гэх мэт/
- Аврах ажиллагааны үеэр тусгай хэрэгцээт хүмүүсийн хувьд онцгой нөхцөл байдалд хэрхэн аврах тухай төлөвлөгөөг эргэн харах, шинэчлэх (шаардлагатай бол нэмэлт нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах гэх зэрэг); /Онцгой байдлыг үйл явцад заасан бусад төлөвлөгөөнүүдэд тусгаж өгөх/
- Өвчилсөн, өөрийгөө тусгаарлах шалтгааны улмаас ажлын байранд сургагдсан ажилтны дутагдал үүссэн тохиолдол онцгой байдалд хариу үзүүлэх чадвартай нэмэлт хүмүүсийг сургаж бэлтгэх; / ГХТХууль 4.1.17, 4.1.18, 13 дугаар зүйл Гал түймэртэй тэмцэх хэсгийн 13.2, 13,3, 13.4 заалтыг судлах, дагаж мөрдөн хэрэгжүүлж ажиллах /
- Цар тахлын хөл хорионы үеэр осол гарах, эмнэлгийн яаралтай тусламж хэрэгтэй болох үед анхны тусламж үзүүлэх хүмүүс, тэдний хэрэглэх нөөц, хамгаалах хувцас хэрэгсэл зэргийг бэлтгэх, хангах; ;/ Ковидын хууль 7.1.4, /
- Уур уцаартай, асуудал үүсгэдэг хүмүүстэй харилцах тухай заавар, хэрхэн ажиллах үйл явцыг тодорхой гаргаж, түгээх, зааварчлах.
- Онц аюултай нөхцөл үүсч, нэн яаралтай онцгой байдалд хариу шаардаж байгаа (химийн бодис асгарах, алдагдах, гал гарах, асуудал үүсч эхлэх) үед биеэр ойртохгүй байх удирдамжийг хэрэгжүүлэх нь хүндрэлтэй байж болно. Энэ тохиолдолд, хүний

амь насыг яаралтай аврахыг нэн түрүүнд чухалчилж үзэх хэрэгтэй; гэхдээ, байгууллага тухайн онцгой нөхцөл байдалд нэмэлтээр COVID-19 –н халдвар тараах эрсдэлээс сэргийлэх төлөвлөгөө гаргаж, боломжит хувилбараар хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй. /ГХТХууль Гуравдугаар бүлэг 15 дугаар зүйл 15.1, 15.2 ГАБТ хуулийн 3.1.6, /

Байгууллага гал унтраах үзүүлэх сургуулилалт хийх, амь аврах, анхны тусламж үзүүлэх сургуулилалт хийх, хүний амь аврах ур чадварыг олгох ажлыг зогсоож болохгүй ба энэ арга хэмжээнүүдээс үүдэн гарах нэмэлт эрсдэлийг үнэлж, гамшгаас хамгаалах төлөвлөгөөгөө шинэчлэн, ажилтнууд болон олон нийтэд мэдээлж, бүх нийтийг мэдлэгжүүлэх хэрэгтэй. Эдгээр үзүүлэх сургуулилалт, дасгал дадлагыг төлөвлөхдөө, байгууллага аюулгүй байдлын нэмэлт хяналт тогтоож, хэрэгжүүлэх хурд ба аргыг тооцох хэрэгтэй, ялангуяа ажлын байрнаас аврах үйл ажиллагаа явуулах үед хоорондын зай барих боломжгүй нөхцөл үүсдэг.

Байгууллага онцгой нөхцөл байдалд бусдад тусалж ажиллах үүрэгтэй ажилтнуудаа нэмэлт эрүүл ахуйн арга хэмжээ яаралтай авч байхыг шаардаж, гар угаах болон ариутгах хэрэгслийг зохих байршлуудад хүртээмжтэй байршуулах хэрэгтэй.

### 4.8 Хязгаарлалтад (хөл хорио) өөрчлөлт оруулах төлөвлөгөө

4.8.1 Байгууллага нь КОВИД-19-тэй холбоотой одоогийн болон гарч болзошгүй эрсдэлийг хянаж, хязгаарлалтыг богино хугацаанд өөрчлөх магадлал (хязгаарлалтад орон нутгийн, бүс нутгийн, үндэсний болон олон улсын зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд нөлөөлж болно) төлөвлөлт байгаа эсэхийг баталгаажуулах ёстой.

Байгууллага үйл ажиллагаагаа аль болох хэвийн үргэлжлүүлэхийн тулд хязгаарлалтанд(хөл хорио) өөрчлөлт ороход хурдан бөгөөд үр дүнтэй хариу өгөх боломжийг бүрдүүлэх арга хэмжээг тодорхойлох ёстой. Төлөвлөлтөнд янз бүрийн болзошгүй нөхцөл байдал, үүнд нэмэгдсэн хязгаарлалт, эсвэл өөр төрлийн хязгаарлалт, хязгаарлалтыг цуцлах зэрэг үйл явцыг харгалзан үзэх шаардлагатай. Төлөвлөлтийг ажилтнууд, ажилтнуудын төлөөлөлтэй зөвлөлдсөний үндсэн дээр хийх ёстой (4.2-ыг үзнэ үү).

Төлөвлөлт хийхдээ байгууллага дараахь зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй.

- Ажлын байранд боломжит хэмжээгээр хамгийн бага тооны ажилтнуудыг хүн хоорондын аюулгүйн зайг баримтлан ажиллуулах эсвэл гэрээс ажиллуулах ;
- Хязгаарлалтын (хөл хорионы) хугацаанд байгууллага үргэлжлүүлэн ажиллах боломжийг олгохын тулд үйл ажиллагаагаа өөрчлөх боломжтой эсэх;
- Үйл ажиллагааг бүрэн буюу хэсэгчлэн түдгэлзүүлэх шаардлага нь зөв эсэх (жишээлбэл нэмэлт арга хэмжээ авах, ажлын үйл ажиллагааг өөрчлөн шинэчлэлт хийгдэх хүртэл үйл ажиллагааг түр зогсоох);
- Өөр хувилбаруудыг хэрэгжүүлэх боломжтой эсэх;
- Тусгай хэрэгцээ, нөхцөл байдалтай ажилтнуудыг харгалзан авч үзэх, тэдгээр ажилтнуудад үзүүлж болзошгүй нөлөөлөл;
- Ажиллагсдын байршлаас шалтгаалан өөр өөр хязгаарлалтанд орж болзошгүй эсэх, түүний нөлөөлөл (жишээлбэл орон нутгийн, бүс нутгийн, үндэсний болон олон улсын хил хязгаарлалтанд орсон ажилтнууд);
- Хангамжид учирч болзошгүй нөлөөлөл ба эдгээрийг зохицуулахад шаардлагатай арга хэмжээ;
- Гэрээт болон түнш байгууллагууд, барилга байгууламжийг хуваалцан, хамтран эзэмшдэг байгууллагууд болон бусад холбогдох сонирхогч талуудтай хамтран ажиллах, харилцаа холбоо тогтоох хэрэгцээ.

4.8.2 Олон төрлийн хязгаарлалтын (хөл хорионы) төлөвлөгөө нь дараахь асуудлыг харгалзан үзнэ. Үүнд:

- Ямар ажилтнуудтай тохиролцох, мэдээлэхээ урьдчилан шийдэх:
- Сайт буюу үйлдвэрлэл дээр зайлшгүй байх шаардлагатай ажилтнууд;
- Гэрээсээ ажиллах шаардлагатай ажилтнууд;
- Огт ажиллах боломжгүй ажилтнууд;

- Ажлын цаг, цалин хөлс болон бусад нөхцлүүдийн талаар мэдээлэх;

в) Үйлчлүүлэгчид болон бусад сонирхогч талуудад хязгаарлалтын (хөл хорионы) өөрчлөлт нь үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөхийг мэдээлэх (жишээлбэл, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, аппликейшн, тэмдэг тэмдэглэгээ, вэбсайтаар дамжуулан).

Байгууллага нь тодорхой хязгаарлалт тогтоовол (жишээлбэл, зочин хүлээж авах үйлчилгээ үзүүлдэг зочид буудал, зоогийн газар гэх мэт) хүн ажиллуулах боломжгүй газар ажилтнуудад үзүүлэх нөлөөг харгалзан үзэж, цалин хөлс зэрэгт гарч болзошгүй өөрчлөлт, нөлөөллийн талаар мэдээлэх ёстой.

Хязгаарлалт (хөл хорио) огцом сулрах тохиолдолд ажилтнуудад үзүүлэх нөлөөллийг мөн харгалзан үзэх хэрэгтэй (жишээлбэл, хүүхэд асрах шаардлагын улмаас богино хугацаанд ажилдаа эргэж очих боломж, ажилтнууд КОВИД-19-ийн халдвар авах эсвэл түүнээс хүнд өвчнөөр өвдөх эрсдэл өндөртэй, эсвэл ийм төрлийн хүмүүстэй хамтран амьдардаг, эсвэл өндөр эрсдэлтэй хүмүүс, өөрсдийгөө тусгаарласан эсвэл хорио цээрийн дэглэмд байгаа ажилтнууд гэх мэт).

Төлөвлөгөөг ажилтнууд болон бусад холбогдох сонирхогч талуудад аль болох  хурдан хугацаанд мэдэгдэх ёстой.

## 5. КОВИД-19-ийн сэжигтэй буюу батлагдсан тохиолдол

*5.1 Ерөнхий*

*5.2 Биеэр гүйцэтгэх ажлын байран дахь өвчлөлийн менежмент*

*5.3 Гэрээсээ ажиллаж буй эсвэл явуулын орчинд ажиллагсдын өвчний менежмент*

*5.4 Шинжилгээ авах, холбоо барих, мөшгилт хийх, хорио цээрийн дэглэм мөрдөх*

### 5.1 Ерөнхий

Байгууллага нь КОВИД -19-ийн сэжигтэй, батлагдсан тохиолдлыг удирдах үйл явцыг бий болгож, мэдээлнэ.

КОВИД -19-ийг ажлын байранд тархахаас урьдчилан сэргийлэх, хязгаарлахын тулд байгууллага нь барилга, байгууламж, ажлын талбайд нэвтрэн орж буй хүмүүсийг үнэлэх, өвчний шинж тэмдэг илэрсэн, өвчний тархалт ихтэй бүс нутгаар аялж, буцаж ирсэн болон КОВИД-19-ийн халдвар авсан хүмүүс нэвтрэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

Бүх түвшний дээд удирдлага, менежерүүд, ажилтнуудад КОВИД-19-ийн шинж тэмдэг илэрвэл өөрийгөө тусгаарлах арга хэмжээ авах, эсвэл шаардлагатай бол хорио цээр тогтоох, хөл хорионд ороход нь дэмжлэг үзүүлэх, тухайн хүнээс үйл явц, хүлээлт ямар байгаа талаар тодруулах, ажилдаа хэрхэн хэзээ эргэн орох талаар мэдээлэл авч, зөвлөгөө удирдлагаар хангана.

Байгууллага дахь КОВИД-19-ийн тархалтын талаар эрүүл мэндийн байгууллагуудад мэдэгдэх ёстой (13.2.2-ыг үзнэ үү).

### 5.2 Биеэр гүйцэтгэх ажлын байран дахь өвчлөлийн менежмент

КОВИД -19-ийн халдварыг багасгах, анхны тусламж үзүүлэгчид, эмнэлгийн ажилтан, тэднээр эмчлүүлж буй хүнийг хамгаалахын тулд ажлын байран дээр бие нь тавгүйрхэж байгаа хүнийг КОВИД -19-ийн болзошгүй тохиолдол гэж үзэх хэрэгтэй.

Байгууллага нь нөхцөл байдлыг харгалзан энэ үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх хүсэлтэй байгаа эсэхийг тодорхойлохын тулд анхны тусламж үзүүлэх үүрэг бүхий ажилтнууд, эмч эмнэлгийн ажилтнуудаасаа зөвлөгөө авах ёстой (жишээлбэл, тухайн ажилтан КОВИД -19-тэй халдвар авах эсвэл хүнд өвчин тусах эрсдэл өндөртэй гэж үзвэл КОВИД -19-аас эрсдэл өндөртэй хүнтэй гэр бүлд амьдардаг, эсвэл ажлын орчинд халдвар авах, халдвар нэмэгдэх вий гэсэн түгшүүртэй бол).

Байгууллага нь:

- Тохиромжтой НБХХ (нүүрний хаалт, бээлий, комбинзон) болон маскаар хангаж, анхны тусламж үзүүлэхэд эдгээрийг хэрхэн ашиглах талаар зааварчилгаа өгөх хэрэгтэй (сонсголын бэрхшээлтэй  хүмүүст анхаарал хандуулж, ийм нөхцөл байдал үүссэн тохиолдолд мэдээллийг зөв өгч, дохионы хэлээр тайлбарлахдаа тунгалаг нүүрний хаалт өмсөх,  хүн хоорондын аюулгүйн зайг баримтлах, хоорондын зайг баримтлах боломжгүй бол бичгээр харилуах зэрэг бусад харилцааны хэлбэрийг ашиглах хэрэгтэй);
- Ажилтны бие  нь тавгүй тохиолдолд анхны тусламж хэрхэн үзүүлэх эсвэл ажлын байран дээрээс тээвэрлэлтийг хэрхэн зохион байгуулах, хэрхэн  тусгаарлах арга хэмжээг тодорхой болгох (жишээлбэл, тухайн хүний гэр бүлийн машинаар хамт амьдардаг хүнээр нь тээвэрлүүлэх гэх мэт);
- Шинж тэмдэг илэрсэн хүнд  маск зүүлгэх  (амьсгалах эрхтэний эрүүл мэндийн суурь өвчтэй хүмүүст анхаарал хандуулах хэрэгтэй), гараа угаах, ариутгахыг хэлэх;
- Шинж тэмдэг илэрсэн  хүнийг аюулгүй тээврийн хэрэгсэл (жишээ нь, боломжтой бол нийтийн тээврийн хэрэгслээс зайлсхийх) ашиглан ажлын байрнаас явах, тохиромжтой аюулгүй газар руу (жишээлбэл, өөрийн гэр эсвэл эмнэлгийн байгууллагад) явахыг шаардах;

*Тэмдэглэл 1: Үүнийг орон нутгийн, бүс нутгийн эсвэл үндэсний удирдамжийн дагуу шаардаж болно.*

- Ажилтанд өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд КОВИД-19-ийн шинжилгээ өгөхийг хүсч, шинжилгээний үр дүнгийн талаар байгууллагад мэдэгдэхийг зөвлөх;
- Халдварт өртсөн байж болзошгүй ажилтан бусад ажилтнууд эсвэл үйлчлүүлэгчидтэй хавьтал үүсгэсэн байсан (жишээлбэл, багаар эсвэл хослон хүн хоорондын аюулгүйн зайг баримтлахгүйгээр ажил гүйцэтгэх, үйлчлүүлэгчид ойртон үйлчилгээ хийх)  эсэхийг тогтоож, хавьтал үүсгэсэн ажилнтууд

эсвэл үйлчлүүлэгчдэд КОВИД-19-т өртөж болзошгүй талаар мэдээлэх, болзошгүй өртөлтийн эх үүсвэрийн нууцлалыг хадгалах, хавьталд орсон ажилтнуудыг нэн даруй тусгаарлах, хорио цээр тогтооход нь дэмжлэг үзүүлэх;

- КОВИД-19ийн халдвар батлагдсан бөгөөд өөрийгөө тусгаарлах илүү өргөн шаардлага гарсан тохиолдолд хавьталд өртсөн ажилтнуудтай холбоо тогтоосон бусад ажилтнуудын дэлгэрэнгүй мэдээллийг хадгалах;
- Халдварт өртсөн хүний орсон, зорчсон аль болох богино хугацаанд тусгаарлах эсвэл цэвэрлэх, ариутгал халдваргүйжүүлэлт хийх, ялангуяа тоног төхөөрөмж, байнга хүрдэг гадаргуу (жишээлбэл хаалганы бариул, цахилгаан шатны товчлуур) болон ариун цэврийн өрөө зэрэг нийтлэг газруудад анхаарал хандуулах;
- Халдвар гарсан барилга байгууламж, талбайг цэвэрлэх, халдваргүйжүүлэх ажлыг гүйцэтгэж буй ажилтнууд зохих НБХХ-ийг ашиглаж, эрсдэлийг үнэлсний үндсэн дээр тохиролцсон аюулгүй ажиллагааны ажиллагааны дүрэм журмыг дагаж мөрдөх;
- Эрүүл мэндийн байгууллагуудад мэдээлэх, жишээ нь хэрэв КОВИД -19-ийн батлагдсан хоёр ба түүнээс дээш тохиолдол ажлын байранд гарсан бол;

*Тэмдэглэл 2: Үүнийг орон нутгийн, бүс нутгийн эсвэл үндэсний удирдамжинд заасны загуу мөрдөж болно.*

- КОВИД -19-ийн халдвар авсан ажилтан хэзээ ажлын байранд эргэж ирэхэд аюулгүй байх талаар тодорхой заавар, удирдамж өгөх;
- Ажилдаа эргэж орох, байнгын дэмжлэг үзүүлэх, нөхөн сэргээх болон ажлыг хөнгөвчлөх арга хэмжээний талаар мэдээлэл өгөх.

### 5.3 Гэрээсээ ажиллаж буй эсвэл явуулын орчинд ажиллагсдын өвчний менежмент

Байгууллага нь гэртээ эсвэл явуулын хэлбэрээр ажиллаж байхдаа

КОВИД -19-ийн шинж тэмдэг илэрсэн ажилтнуудыг удирдах, зохион байгуулах үйл явцыг бий болгох ёстой. Байгууллага дараахь зүйлийг баталгаажуулах шаардлагатай. Үүнд:

- Ажилтанд өвчний шинж тэмдэг илэрвэл даруй байгууллагад мэдээлэхийг зөвлөх;
- Шинж тэмдэг илэрсэн хүн ажлын байраа хэрхэн орхин явах, хэрэв тухайн хүн гэрээс гадуур, хөдөлгөөнт байдлаар ажил үүргээ гүйцэтгэж байсан бол аюулгүй тээврийн хэрэгсэд ашиглан (жишээ нь, боломжтой бол нийтийн тээврээс зайлсхийх) тохиромжтой аюулгүй газарт очих (жишээлбэл, гэр эсвэл эмнэлгийн байгууллагад);

*Тэмдэглэл: Үүнийг орон нутгийн, бүс нутгийн эсвэл үндэсний удирдамжанд заасны дагуу мөрдөж болно.*

- Ажилтнууд өөрсдийгөө тусгаарлах, хөл хорио тогтоохтой холбоотой журмуудыг мэддэг, дагаж мөрддөг байх, (үүнд ажилтнууд КОВИД-19 өвчтэй хүнтэй ойр дотно эсвэл удаан хугацаагаар ойрын хавьтал тогтоосон бол мөн дагаж мөрдөнө);
- Халдварт өртсөн ажилтантай байнга холбоо тогтоож, цаашид шинж тэмдгүүд даамжрах, хүндээр өвдсөн эсэхийг тодорхойлох;
- Халдварт өртсөн ажилтнууд гэрээсээ ажиллах үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн хийх ёстой эсэх, ажлаа үргэлжлүүлэхэд биеийн байдал сайн байгаа эсэх, эсвэл тодорхой хугацаанд өвчний чөлөө авах шаардлагатай эсэх;
- Ажилтнууд өөрийгөө тусгаарласны дараа эсвэл КОВИД-19-ийн халдвар эмчлэгдсэний дараа ажлын үйл ажиллагаандаа эргэж орох үйл явцыг ойлгодог, мэддэг байх;
- Шаардлагатай тохиолдолд бие махбодийн болон сэтгэлзүйн хэрэгцээг харгалзан КОВИД -19-р өвчилж, эдгэсний дараа хөдөлмөрийн үйл ажиллагаанд эргэн ирж буй ажилтанд дэмжлэг үзүүлэх зохион байгуулалт, төлөвлөгөө хийх.

### 5.4 Шинжилгээ авах, холбоо барих, мөшгилт хийх, хорио цээрийн дэглэм мөрдөх

Байгууллага нь шинжилгээ авах, холбоо барих мөшгилт хийх, хорио цээрийн дэглэм мөрдөх талаар холбогдох хууль тогтоомж, холбогдох зохицуулагч, эрүүл мэндийн байгууллагуудын удирдамжийг бүрэн мэдэж байхын тулд арга хэмжээ авах ёстой.

*Тэмдэглэл: Орон нутгийн, бүс нутгийн эсвэл үндэсний удирдамжийг даган мөрдөж ажиллаж болно.*

Нэмэлтээр байгууллагууд дараахь зүйлийг хийх ёстой.

- Шинж тэмдэг илэрсэн ажилттнуудыг яаралтай шинжилгээ өгөхийг уриалах;
- Бусад хүмүүстэй харилцаж ажилладаг ажилтнууд, түүний дотор шинж илрээгүй ажилтнуудыг тогтмол шинжилгээ өгөхийг дэмжих;
- Эрүүл мэнд, шинж тэмдгийг хянах апликэйшн, судалгааны сайтыг ашиглахыг дэмжих;
- Бусад байгууллагад очдог ажилтнууд эсвэл хүмүүсийн дэлгэрэнгүй мэдээллийг аль болох авах , нууцлалыг чандлан хадгалах замаар холбоо барих, мөшгих ажиллагааг дэмжих;
- Ажилтнууд болон бусад холбогдох сонирхогч талуудаас шаардлагатай тохиолдолд хорио цээрийн дэглэм тогтоохыг дараахь шалтгаанаар шаардана.

1) Аялал, зорчилтын хязгаарлалт;

2) Холбоо барих, мөшгих ажлыг эрүүл мэндийн байгууллагуудын зөвлөгөө, эсвэл програм эсвэл бусад харилцаа холбоогоор дамжуулан мэдээлэл авах;

- Ажилтай холбоотой үйл ажиллагаа нь гэртээ ажиллаж буй эсвэл өөр газарт байрлан ажиллаж буйгаас үл хамааран хөл хориond орсон тохиолдолд тохиолдолд хувь хүний хэрэгцээ, нөхцөл байдлыг харгалзан үзэх, шаардлагатай бол хорио цээрийн хугацаанд зардлыг олгох;

- Ажилтай холбоогүй үйл ажиллагаанаас шалтгаалан хорио цээр тогтооход шаардлагатай ажилтнуудад аль болох боломжийн удирдамжаар хангах ажиллах (жишээлбэл, хувиараа аялсан бол ирээд заавал хөл хорионд орох), хэрэв шаардлагатай бол ажилтнуудад ээлжийн амралт, цалинтай болон цалингүй чөлөө авах боломжийг олгох;
- Цар тахлын үеэр хувиараа аялах бодлого журмыг нийт ажилтнуудад тодорхой болгож танилцуулах.

## 6. Сэтгэлзүйн эрүүл мэнд, сайн сайхан байдал

6.1 Байгууллага нь цар тахлын үеэр ажилтнуудын сэтгэлзүйн эрүүл мэнд, сайн сайхан байдалд үзүүлэх нөлөөллийг удирдах үйл явцыг бий болгох ёстой.

Сэтгэлзүйн эрүүл мэнд, сайн сайхан байдалд дараахь сэтгэлзүйн нөлөөллүүд нөлөөлж болно. Үүнд:

- Тодорхойгүй байдал (ж нь, хүлээгдэж буй үр дүн, зохицуулалт, хэр удаан үргэлжлэх, цалин хөлс эсвэл ажлын цагт нөлөөлөх нөлөөллийн талаар);
- Ажлын ачаалал ба ажлын хурд (ж нь, хэт их эсвэл хэт бага ажил, нэмэлт, өөрчлөлт оруулсан арга хэлбэрийн улмаас үйл ажиллагаа удаан үргэлжилж байгаа ч гэсэн богино хугацаанд хүрэх хүлээлт);
- Ажлын цаг (ж нь, урьдчилан таамаглах боломжгүй цаг, багасгасан эсвэл уртасгасан цаг, шинэ ээлжээр ажиллах хэв маяг);
- Ажил үүргийн тодорхойгүй байдал, хоёрдмол байдал (ж.нь Ажил үүргийн хуваарьт өөрчлөлт оруулах, шинэ үүрэг гүйцэтгэх, тодорхойгүй байх);
- Хяналтгүй байдал, үйл ажиллагаа (ж нь, эрсдэлийн түвшин огцом өөрчлөгдөх, хязгаарлалт, хөл хорио гэнэт чангарах эсвэл сулрах, эсвэл ажлын арга хэлбэр өөрчлөгдөх);
- Нийгмийн дэмжлэг байхгүй (ж нь, ганцаардал, тусгаарлалт, харилцааны асуудал);

- Удаан хугацаагаар тусгаарлалтанд байх, зайнаас ажиллах нөлөөлөл (ж нь, дэлгэцэнд хэт өртөх, ядрах, уйдах, анхаарал төвлөрөхгүй байх, нойргүйдэх);
- Ажлын байрны тогтвортой байдал (ж нь, ажилгүй болох айдас, өрхийн санхүүгийн асуудалд санаа зовох);
- Ажил, гэрийн амьдралыг тэнцвэржүүлэхэд бэрхшээлтэй байх (ж нь, анхаарал халамж тавих үүрэг хариуцлага, гэр бүлийн онцгой байдал, ажлын хэвийн бус цагаар ажиллах шаардлагатай);
- Бусад хүмүүстэй ойр ойрхон, удаан хугацаагаар харьцсаны улмаас өндөр эрсдэлтэй гэж тодорхойлогдох ажил үүрэг (ж нь, удирдах ажил, олон нийтийн нүүр царай, хөдөлгөөнт ажил);
- Ажилтнуудын онцгой нөхцөл байдал (ж нь, эмзэг бүлэгт хамаарах, гэр бүлийн гишүүнээ алдах, өөрөө болон гэр бүлийн гишүүн хүнд өвчин тусах).

6.2 КОВИД -19-тэй холбоотойгоор ажилтнуудын сэтгэлзүйн эрүүл мэнд, сайн сайхан байдалд учрах эрсдэлийг удирдахын тулд байгууллага дараахь зүйлийг хийх ёстой.

- Ажилтнуудад хувийн өөр өөр асуудалтай тулгарч, сэтгэлийн түгшүүр, бэрхшээл тулгарахад ойлгодог, хүндэтгэн үздэг гэдгийг нийтээрээ хүлээн зөвшөөрч итгэлцэл, хамтран ажиллагсад нэгнээ халамжлах, дэмжих соёлыг сурталчлах;
- Тулгарч буй асуудал, айдас түгшүүрийн талаар ярилцаж, ажилтнуудаа дэмжих, тэдэнтэй хамтрах арга замыг тохиролцох зорилгоор тогтмол ганцаарчилсан уулзалтуудыг (зайнаас болон хоорондын аюулгүйн зайг баримтлан биеэр) зохион байгуулах;
- Хэсэг нэгж, багийн ажилтнуудтай зайнаас эсвэл биечлэн уулзах уулзалт тогтмол хийх;
- Ажлын болон амралтын уян хатан цагийг бий болгох;
- Ажиллагсдад ажил гүйцэтгэх уян хатан байдлын хэрэгцээг харгалзан ажиллах, ажлын биелэлтийг гаргуулах хугацааг урьдчлан нь мэдээлэх замаар ажлын болон ажлын бус цагийн хоорондох хил хязгаарыг тогтооход нь туслах;

- Боломжтой бол ажилтнуудад ажлын хурд, үүрэг даалгавар гүйцэтгэж дуусах эцсийн хугацааг сонгох боломжийг олгох;
- Байгууллагын өнөөгийн байдал, ажилтнуудад нөлөөлж болзошгүй өөрчлөлтийн талаар тогтмол, тодорхой, үнэн зөв мэдээлэл өгөх;
- Байгууллагад шаардлагагүй байсан ч биеэр гүйцэтгэх ажлын байран дээр очих тохиолдол гарч болзошгүй тул ажилтнуудад тохирсон НБХХ, маск, нүүрний хаалт болон бусад хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх, бэлэн байлгах;
- Ажилтнуудад өөрсдийн сэтгэлзүйн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг удирдахад туслах нэмэлт эх үүсвэрийг санал болгох (жишээлбэл, онлайн хөтөлбөр, вэбсайт, гэр бүлийн гишүүнээ алдсан болон гэмтсэн үед зөвлөгөө өгөх мэргэжилтнүүдэд хандах, санхүүгийн зөвлөгөө өгөх).

*Тэмдэглэл: Сэтгэлзүйн эрүүл мэндийн менежментийн талаархи нэмэлт зааврыг ISO 45003 ба ISO 10075 цувралд заасан болно.*

## 7. Хамрах хүрээ

Байгууллага нь КОВИД -19-ээс шалтгаалан хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдалд учирч болзошгүй эрсдэлийг зохицуулахын тулд төрөл бүрийн ажил үүрэг бүхий ажилтнууд болон бусад холбогдох сонирхогч талуудад үзүүлж буй нөлөөллийг харгалзан үзэх ёстой.

Байгууллага, жишээлбэл доорхи зүйлсийг ханган ажиллах ёстой:

- Тулгарсан асуудал, болгоомжлолыг хүндэтгэж, тавьсан хүсэлтийг боломжийн хэрээр хангах, баталгаажуулах;
- Гэрээсээ ажиллах үйл ажиллагааг үр дүнтэй гүйцэтгэх чадвартай, ажлын байрандаа эргэж очихоос санаа зовж, түгшиж буй ажилтнуудын гэрээс ажиллах ажлыг үргэлжлүүлэн дэмжих;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай хэрэгцээний талаархи нийт ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлэх, ажилтнуудад сургалт явуулах (жишээлбэл, тохиромжтой ариун цэврийн өрөөнд

орох боломжийг олгох, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслах үүргийг гүйцэтгэдэг амьтдыг хэрхэн сургадаг, удирддаг, маск эсвэл нүүрний хаалт хэрэглэсний улмаас үүссэн харилцааны бэрхшээлийг бууруулах арга хэмжээ авах гэх мэт);

- Мөргөл, залбирал үйлдэхэд зориулсан байгууламжууд руу аюулгүй байдлаар нэвтрүүлэх;
- Боломжтой бол зорилтот, эмзэг бүлгийн ажилтнуудад учрах эрсдэлийг бууруулах, үйл ажиллагааг зохицуулах;
- Харилцаа холбоо: үүнд цахим харилцаа холбоо, тухайлбал, вэбсайт, онлайн уулзалт эсвэл захиалгын систем) нэвтрэх боломжтой байх.

Хүртээмжтэй байдал, хамрагдах байдлын талаархи нэмэлт мэдээллийг Хавсралт Б-д үзүүлэв.

## 8. Нөөц

Байгууллага нь КОВИД-19-тэй холбоотой эрсдэлийг үр дүнтэй удирдахад шаардлагатай нөөцийг тодорхойлж, хангалттай нөөцийг бүрдүүлэх ёстой. Байгууллага нь шаардлагатай нөөцийг зохих ёсоор удирдаж, шаардлагатай бол найдвартай хангаж өгөхөд туслах үйл явцыг бий болгох ёстой.

КОВИД-19-тэй холбоотой эрсдэлийг бууруулах, нөөцийг удирдах үүрэгтэй ажилтнуудыг тодорхойлсон байх ёстой бөгөөд энэ талаар нийт ажилтнууд болон бусад сонирхогч талуудад мэдэгдэх ёстой. Байгууллага нь КОВИД-19-тэй холбоотой эрсдэлийг удирдах, ажилтнуудын нөөцийн тодорхой хэрэгцээ, шаардлагын талаар ажилтнуудтай байнгын яриа хэлэлцээрийг хийж, идэвхжүүлэх үйл явцыг хангах ёстой.

Шаардлагатай үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэх, хадгалахад шаардлагатай нөөцийг тодорхойлохдоо байгууллага дараахь зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй.

- Хүний нөөц, түүний дотор ажилтнуудад үзүүлэх биет болон сэтгэлзүйн дэмжлэг, өвчилсөн эсвэл тусгаарлагдсанаас шалтгаалан цөөрсөн ажиллах хүчний нөөцийг удирдах үйл явц;

- Санхүүгийн эх үүсвэр;
- Зохих НБХХ, үүнд цэвэрлэгээ, ариутгалын үүрэг бүхий ажилтнуудад зориулсан тусгай хангамж;
- Гар угаах, гар ариутгах, цэвэрлэгээ, ариутгалын материал;
- Хүрэлцээтэй, аюулгүй ариун цэврийн байгууламжаар хангах;
- Технологи;
- Дэд бүтэц, тоног төхөөрөмж (жишээлбэл, хог хаягдал, ус, эрчим хүчний менежменттэй холбоотой);
- Харилцааны арга хэрэгсэл (9-р зүйл);
- Ажилтнуудыг нэмэлт үүрэг эсвэл үйл ажиллагаа эрхлэх чадвартай болгохын тулд нэмэлт сургалтуудын хэрэгцээ, түүний бэлэн байдал.

Байгууллага нь ажилтнуудын түр хугацаагаар, удаан хугацаагаар эсвэл бүр мөсөн байхгүй байх аль ч үед (өвчилсөн, өөрийгөө тусгаарласан, хорио цээрийн дэглэм, ажлын байраа алдах зэргээр) ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулахгүй байх ёстой. Байгууллага нь ажилтнуудаа гүйцэтгэх ёстой үүрэг, үйл ажиллагаагаа гүйцэтгэж чадах эсэх, ялангуяа шинэ, нэмэлт ажил үүрэг гүйцэтгэж буй ажилтнуудын чадварыг үнэлэх ёстой.

Байгууллага нь нэмэлт ачааллыг багасгах арга хэмжээ авч, нэмэлт ачаалал бүхий үүрэг даалгавар, ажлыг зөвхөн богино хугацаанд өгнө. Шууд удирдлага, менежерүүд нэмэлт ажлын ачаалал, нөлөөлөлд өртөж буй ажилтнуудад үзүүлж буй нөлөөллийг хянах ёстой бөгөөд ингэснээр ажилтан тус бүрд тохиролцсон ажлын цагаас хэтрэхгүй ажиллах, амрах нөхцөл бололцоогоор хангаж өгөх ёстой.

## 9. Харилцаа холбоо




### 9.1 Ерөнхий зүйл

9.1.1 Байгууллага нь КОВИД -19-тэй холбоотой эрсдэлийг удирдах үүрэг амлалт авч, ажилтнууд болон сонирхогч талуудад дараахь зүйлийг мэдээлэх ёстой.

- Аюулгүй ажиллагааны ерөнхий арга хэмжээ, хяналт;
- Ганцаарчилсан болон багаар ажиллах ажилтнуудын хэрэгцээг харгалзан шаардагдах ажлын арга хэлбэр;
- Байгууллагын зүгээс ажилтнууд болон сонирхогч талуудаас хүлээж буй хүлээлт;
- Ажилтнууд болон сонирхогч талуудын байгууллагаас хүлээж буй хүлээлт;
- Асуудал, аюулгүй тохиолдол гарахад хэрхэн мэдээлэх талаар.

Байгууллага нь цар тахлын үеэр авч хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа нь тохиролцсон арга хэлбэртээ туушта байгаагаа харуулахын тулд дээд түвшний удирдлагуудаас бүх түвшний ажилтнуудтай тогтмол харилцаа холбоотой байж, мэдээлдээр хангах ёстой.

9.1.2 Байгууллага нь албан ба албан бус харилцааны аргуудыг (дотоод сүлжээ, вэбсайт, имэйл, тэмдэг тэмдэглэгээ, зураг, утсаар

харилцах, аудио зар, видео гэх мэт) хослуулан ашиглах ёстой бөгөөд ингэснээр мэдээлэл мессежүүд холбогдох хүмүүс, сонирхогч талуудад хүрэх боломжтой бөгөөд энэ нь ойлгомжтой байх ёстой. Үүнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, гадаад хүмүүс ажилтнууд болон бичиг үсгийн түвшин ялгаатай хүмүүс орно. Байгууллага нь буруу тайлбар, ойлголт өгөхөөс зайлсхийхийн тулд аль болох стандартчилагдсан тэмдэг тэмдэглэгээг ашиглахыг баталгаажуулах ёстой.

Харилцаа холбооны давуу аргуудыг (жишээлбэл, багуудтай видео хурал хийхээс илүүтэй хувь хүнд имэйл илгээх эсвэл биечлэн утсаар ярих гэх мэт) тусгай хэрэгцээт ажилтнуудад үүнд өвөрмөц өөрчлөлттэй (жишээлбэл дислекси, аутизм, диспракси) ажилтнуудад тохирсон байхыг анхаарч үзэх хэрэгтэй.

Ажилтнууд болон сонирхогч талуудтай харилцах харилцаа нь хоёр талт байх бөгөөд албан ёсны зөвлөгөөнөөс харилцан ярилцсаж тохиролцсон байх нь илүү дөхөмтэй байна.

Харилцаа холбоо үүсгэхэд хүн хоорондын зай, эрүүл ахуйн дадал зуршлын талаар тодорхой бөгөөд хамгийн сүүлийн үеийн удирдамжийг хангаж, дагаж мөрдөх ёстой. Үүнд:

- Ажлын байранд ирэхээсээ өмнө харилцах (жишээлбэл, утас, вэбсайт, дотоод сүлжээ, имэйлээр);
- Ажлын байранд ирэхэд (жишээлбэл, тэмдэг, зурагт хуудас, дэлгэц, зарлал);
- Ажлын байранд анх ороход (9.2 ба 12.2-ыг үзнэ үү);
- Ажлын байрны дотор гадна талд (жишээлбэл, тэмдэг, зурагт хуудас, дэлгэц, зарлал).

Барилга байгууламжаас гадна, бусад газар, эд зүйлс, олон хүн харилцдаг чиг үүргийн газар, өрөөнүүдэд тодорхой зааварчилгааг байршуулах ёстой. (жишээлбэл, цайны газар, хөргөгч, дундын тоног төхөөрөмж, анхны тусламж үзүүлэх газар, хүний нөөцийн алба, мэдээлэл технологийн алба гэх мэт).

9.1.3 КОВИД-19-тэй холбоотой үйл явц, удирдамж, эрсдэлийн түвшинг өөрчлөгдсөн талаар тогтмол харилцаа холбоотой байж, мэдээлэл дамжуулж байх ёстой.

Байгууллага нь:

- Зочид, хүргэлтийн ажилтнууд, үйлчлүүлэгчид болон бусад хүмүүст аюулгүй байдлын удирдамжийг хүргэх, зааварчилгаа өгөх үүргийг хэн хариуцахыг тогтоох (энэ үүргийг гүйцэтгэхэд нэгээс олон хүн сургагдсан байх);
- Мэдээлэл дамжуулж буй харилцаа холбооны суваг, хэрэгслийг бүх ажилтнууд болон сонирхогч талууд, үүнд гэрээлэгчид, бусад агентлагийн ажилтнуудад хүртээмжтэй, ашиглах боломжтой байлгах;
- Зочдыг хүлээн авах үүрэг гүйцэтгэдэг, эсвэл хүргэлтийн ажилтнууд, үйлчлүүлэгчид, олон нийттэй харилцах шаардлагатай ажилтнуудад шаардлагатай сургалтыг зохион байгуулах;
- Үйл ажиллагааны өөрчлөлт, аюулгүй ажиллагааны арга хэмжээ, хяналтын талаар холбогдох мэдээллийг ханган нийлүүлэгчид, үйлчлүүлэгчид болон бусад сонирхогч талуудад хүргэх;
- Харилцаа холбоог сүүлийн үеийн, үр дүнтэй байлгах үүднээс ойр ойрхон хянаж, асуудал илэрвэл арга хэмжээ авах;
- Хүн хоорондын аюулгүйн зайны шаардлагыг хангах, үүнд хүн хооронд хүрэлцэх дуу чимээний түвшин өндөр байлгах, буурах боломжгүй байх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор үр дүнтэй харилцааны өдөр тутмын механизмыг ажлын байранд бий болгох.

### 9.2 Ажлын байранд анх нэвтрэн орох

Байгууллага нь ажилтнууд болон бусад сонирхогч талууд КОВИД -19-ийн тархалтаас сэргийлэн ажлын байранд анх орохоосоо өмнө эсвэл тодорхой хугацааны дараа ажлын байранд буцаж ирэхээс өмнө дамжих эрсдэлийг зохицуулахад шаардагдах үйл явц, ажлын дадлыг ойлгохын тулд бүх боломжийн арга хэмжээг авах ёстой.

9.1-д заасан үйл ажиллагаанаас гадна байгууллага дараахь зүйлийг хийх ёстой.

- Харилцаа холбоо, сургалтын материалыг боловсруулж,

шаардлагатай бол сургалтанд хамруулах (жишээлбэл, видео сургалт эсвэл цахим аргаар);

- Ажилдаа аюулгүй буцаж ирэх, холын болон ойрын аяллын талаар зааварчилгаа өгөх (боломжтой бол алхах, дугуй унах, хувийн тээврийн хэрэгслийг ашиглахыг уриалах, ажилтнууд нийтийн тээврээр үйлчлүүлэх зайлшгүй шаардлагатай хүн хоорондын зай, маск, нүүрний хаалт зэргийг хэрэглэхийг дэмжих);
- Ажил эхлэх, дуусах үе шат, цаг, ажлын уян хатан цаг, ээлжийн хуваарь эсвэл бусад өөрчлөгдсөн ажлын хэв маяг, хуваарийн талаар тодорхой зааварчилгаа өгөх;
- Хүн хоорондын аюулгүйн зай, эрүүл ахуй, ажлын ерөнхий аргуудын талаар зааварчилгаа өгөх;
- Ажлын байранд нэвтрэх, ажил эхлэх, нийтийн эзэмшлийн талбайг ашиглах шинэ үйл явцыг (жишээлбэл, цахилгаан шат / урсдаг шат, энгийн шат, бие засах газар, гал тогоо, коридор) мэдээлэх;
- Зочид, үйлчлүүлэгчид, үйлчилгээ хэрэглэгчид болон бусад хүмүүстэй аюулгүй харилцах талаархи удирдамжийг сурталчлах;
- Онцгой байдлын журамд гарсан өөрчлөлтийг мэдээлэх (4.7-г үзнэ үү).

### 9.3 Байнгын харилцаа холбоо, зарлан мэдээлэл

Байгууллага нь аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээ, хяналтыг бүх ажилтнуудад байнга сануулж, тэдгээрийг өөрчилсөн эсвэл аюулгүй ажиллагааны нэмэлт арга хэмжээ, хяналтыг хэрэгжүүлсэн тохиолдолд шинэчилсэн мэдээлийг байнга хүргэж байх ёстой.

Байгууллага нь:

- Ажилтнууд болон ажилтнуудын төлөөлөлтэй байнгын харилцаа холбоог тогтоож, ажлын байрны хэв маяг, ажлын зохион байгуулалт, ажлын байрны өөрчлөлтийн урьдчилан таамаглаагүй нөхцөл, нөлөөллийг ойлгуулах арга хэмжээ авах (4.4-ийг үзнэ үү);

- Ажилтнууд, түүний дотор зайнаас ажилладаг хүмүүстэй тогтмол харьцаж, бие махбодь, сэтгэлзүйн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг шалгаж, сэтгэлзүйн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй асуудлын талаар тодорхой мэдээлэл өгөх (6-р зүйлийг үз).

## 10. Эрүүл ахуй

10.1 Байгууллага нь ажлын байраа цэвэр байлгах, бохирдсон гадаргуугаас КОВИД-19 дамжих эрсдэлийг бууруулах, ажлын цагаар болон ажлын ээлж бүрийн төгсгөлд эрүүл ахуйг сахих үйл явцыг хэрэгжүүлэх ёстой.

Байгууллага нь КОВИД-19 дамжилтыг хязгаарлахын тулд гараа тогтмол, сайн угааж байхын ач холбогдлыг ажилтнуудад ойлгуулах ёстой. Байгууллага ажилтнуудад дараахь санамжуудыг хүргэх ёстой:

- Гараа 20-оос 40 секундын турш цэвэр ус (халуун усаар угаах илүү зохимжтой), савангаар угаана;
- Гар угаах боломжгүй бол гарыг КОВИД -19-ийн эсрэг аюулгүй, үр дүнтэй, тохиромжтой гар ариутгагч бодисоор ариутгасан байх ёстой (жишээлбэл, хамгийн багадаа 60% этанол буюу 70% изопропилийн спирт агуулсан);
- Боломжтой бол гар ариутгагч хэрэглэхээс өмнө бохирдсон гараа угаах хэрэгтэй.

Байгууллага нь гар ариутгагч бодисыг холбогдох стандартад нийцүүлж байгаа эсэхийг баталгаажуулах (жишээлбэл шошгон дээрх спиртийн төрөл, агууламжийг шалгах), хуурамч, чанар муутай, эсвэл буруу боловсруулсан бүтээгдэхүүн худалдан авах магадлалтай гэдгийг анхаарч байх ёстой.

10.2 Байгууллага дараахь зүйлийг хангах үйл явцыг хэрэгжүүлэх ёстой.

- Ажилтнууд гараа ойр ойрхон угаах (эсвэл боломжгүй бол ариутгах хэрэгтэй), үүнд: жишээлбэл, ажлын байрны аль нэг хэсэгт орох, гарахаас өмнө, завсарлагааны өмнө ба дараа, утас, компьютер, багаж хэрэгсэл, ус буцалгагч, кофе чанагч

зэрэг дундын нөөцийг ашиглах, нийтийн эзэмшлийн талбайг ашиглахаас өмнө ба дараа);

- Ажилтнууд байгаа эсвэл дамжин өнгөрч буй газруудад нэмэлт гар угаах ба / эсвэл гар ариутгах байгууламжтай байх (жишээлбэл, орц, гарц, цахилгаан шатны ойролцоо, нийтийн эзэмшлийн талбай, ашиглалтын талбай);
- Ажилтнуудад ажлын байр, тоног төхөөрөмжийг байнга цэвэрлэх, халдваргүйжүүлэх боломжийг бүрдүүлэх нэмэлт материалыг авах боломжтой байх;
- Тогтмол хүрдэг гадаргууг байнга цэвэрлэж, халдваргүйжүүлэх (жишээлбэл хаалганы бариул, гэрлийн унтраалга, лангуу, төлбөрийн цэг, туршилтын гадаргуу, өргөх / цахилгаан шатны хяналт, дундын нөөц);
- Нэг удаагийн НБХХ, нэг удаагийн маск, нүүрний хаалт хаяхад зориулагдсан хог хаях цэгийг тусад нь хаях, тэдгээр хог хаягдлыг аюулгүй байдлаар, ойр ойрхон ажлын байрнаас холдуулах, зайлуулах;
- Ажилтнуудад гар угаах шаардлагатай техник, давтамж, нүүрэнд хүрэхээс зайлсхийх, нэг удаагийн салфетка, алчуур эсвэл тохойн хэсэгт ханиах, найтаах зэргийг сануулсан зурагт хуудас, самбар зэрэг эрүүл ахуйн зөв дадлыг сурталчлах;
- Ариун цэврийн өрөөний аюулгүй ажиллагааг хангах, үүнд агааржуулалтыг нэмэгдүүлэх, сайжруулсан, цэвэрлэгээ ариутгал хийх давтамжийг ойртуулах, цаасан алчуур ашиглахыг уриалах, хүний бөөгнөрлийг багасгах зорилгоор хэрэглээг зохицуулах (12.6.2-ыг үзнэ үү);
- Шүршүүр, хувцас солих өрөөг аюулгүй ашиглах, боломжтой бол цөөн хүнд зориулсан тусгай өрөө тасалгаа бий болгох.

10.3 Гадаргууг бохирдуулахгүй байхын тулд, мөн гадаргууд байнга хүрэлцэхээс сэргийлж, байгууллага нь тогтсон ажлын байр, бүс, ширээ ба / эсвэл тоног төхөөрөмжийг ашиглах, ажилтнуудаас хувийн эд зүйлсээ шүүгээ, цүнх гэх мэт хувийн орон зайд байлгахыг шаардах, ажил дуусахад ажлын байран дахь хувийн эд зүйлсийг ажлын байран дээр ил байлгахгүй байх, орхихгүй байх.

Байгууллага нь КОВИД-19-ийг ажлын байранд оруулж ирсэн эд зүйлс, бараа материал, байгууллагын ашиглаж буй тээврийн хэрэгслээр дамжих эрсдэлийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авах ёстой. Байгууллага нь:

- Нэн шаардлагагүй ач холбогдолгүй хүргэлт, түүний дотор ажилтнуудад хувийн хүргэлт хийхийг хязгаарлах;
- Ажлын байранд орж буй материал, тоног төхөөрөмж, бусад зүйлийг цэвэрлэх, ариутгах;
- Ашиглалт бүрийн дараа дундын тоног төхөөрөмжийн хүрэлцэх цэгийг цэвэрлэж ариутгана;
- Ажил эрхлэхэд ашигладаг тээврийн хэрэгслийг, түүний дотор ажилтнуудын гэр рүүгээ явдаг тээврийн хэрэгслийг тогтмол цэвэрлэж, ариутгаж байх;
- Хүргэлт хийж буй ажилтнуудын гар угаах давтамжийг нэмэгдүүлэх, эсвэл гар угаах нь тохиромжтой биш бол гар ариутгагч бодисоор хангах.

## 11. Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, маск, нүүрний хаалт ашиглах

11.1 НБХХ нь хэрэглэгчийг ажлын байран дахь эрүүл мэнд, аюулгүй байдалд учрах эрсдэлээс хамгаалдаг. КОВИД-19-ийн хүрээнд амьсгалын тоног төхөөрөмж, нүүрний хаалт (үүнийг масктай хамт хэрэглэнэ) гэх мэт НБХХ ашиглаж болно. Хэрэв ажилтнууд КОВИД-19-н тархалттай холбоогүй эрсдэлээс хамгаалах хэрэглэх ёстой НБХХ ашиглах шаардлагатай бол үүнийг үргэлжлүүлэн хэрэглэнэ..

Амны хаалт, нүүрний хаалт, даавуун материалаар хийсэн нүүрний хаалт, маск нь амьсгалын замын, ханиалгах, найтаах, ярих замаар ялгарч буй агаар дуслыг барьж КОВИД-19-ийн халдвараас зарим талаар хамгаалдаг гэдэг нь нотлогдсон. Хүн хоорондын зайг баримтлах, гар угаах болон бусад нүүрний хаалт, маск хэрэглэх нь (10-р зүйлийг үзнэ үү) нь КОВИД -19-тэй холбоотой эрсдэлийг бууруулах үр дүнтэй арга хэмжээ юм.

Мэргэжлийн НБХХ ба эмнэлгийн хэрэгслийг (жишээлбэл, ажилтнуудыг тоос шороо болон бусад аж үйлдвэрийн агаараас үүсэх аюулаас хамгаалах маск гэх мэт) үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай хүмүүст зориулж хадгалах хэрэгтэй.

11.2 Байгууллага нь НБХХ, маск ба / эсвэл нүүрний хаалтыг түр хугацаагаар авах шаардлагатай нөхцөл байдлыг харгалзан үзэж, ажилтнууд, сонирхогч талуудад мэдээлэл өгнө. Үүнд:

- Таних болон бусад аюулгүй байдал, харуул хамгаалалтын зорилгоор маск, нүүрний хаалтыг түр хугацаагаар авах;
- Амны хөдөлгөөнөөр уншдаг сонсголын бэрхшээлтэй ажилтнууд болон бусад сонирхогч талуудтай харилцах.

Хэрэв НБХХ, маск ба / эсвэл нүүрний хаалтыг түр зуур авах шаардлагатай бол хүн хоорондын аюулгүйн зайг заавал баримтлах шаардлагатай. НБХХ, маск, нүүрний хаалт өмсөх, тайлахаас өмнө гадна бохирдлоос зайлсхийхийн тулд гар угаах (эсвэл ариутгах) арга хэмжээ авах хэрэгтэй. Дохионы хэл ашиглагдаг хүмүүс болон бусад сонирхогч талуудын харилцаа холбоог сайжруулахын тулд байгууллага нь нүүрний тохирох тунгалаг хаалтыг ашиглах ёстой.

11.3 Хэрэв КОВИД-19-тэй холбоотой эрсдэлийг зохицуулахын тулд нэмэлт НБХХ, маск эсвэл нүүрний хаалт ашиглах шаардлагатай бол байгууллага дараахь зүйлийг хийх ёстой.

- НБХХ, маск ба / эсвэл нүүрний хаалтыг хэзээ, хэрхэн хэрэглэх талаар зааварчилгаа гаргаж, шаардлагатай бол сургалт зохион байгуулах;
- Тохирох НБХХ ба / эсвэл маскыг үнэ төлбөргүй олгох;
- НБХХ ба маскыг зөв зүүсэн, хэрэглэсэн эсэхийг баталгаажуулах, ашигласны дараа аюулгүй хаях талаар ажилчдад зааварчилгаа өгөх;
- Аюулгүй ажиллагааны арга хэмжээг дагаж мөрдөх, тоног төхөөрөмжийн ашиглалтын аюулгүй байдлыг хангахад шаардлагатай НБХХ-ийг хэрэглэснээс үүдсэн ядаргаа багасгах зорилгоор ажилчдыг тогтмол завсарлага авахыг уриалах;

- Бохирдсон, дахин ашиглах боломжтой НБХХ-ийг цэвэрлэх, ариутгах, угаах.

Байгууллага нь зайлшгүй шаардаагүй маск эсвэл нүүрний хаалт хэрэглэхийг сонгосон ажилтнуудыг дэмжинэ. (жишээлбэл, гар хийцийн нүүрний хаалт, маск эсвэл байгууллагаас өгөөгүй бусад нүүрний хаалт, маск).

*Тэмдэглэл: Тодорхой тохиолдлуудад стандарт бус НБХХ-ийг хууль ёсны шаардлага эсвэл бусад шаардлагуудаар хориглож болно.*

**11.4 Байгууллага ажилтнуудаа дараахь зүйлийг зөвлөх ёстой.**

- Маск, нүүрний хаалтыг зүүх, эсвэл авсны дараа гараа угаах буюу гар ариутгагч хэрэглэх (боломжтой бол гар ариутгагч хэрэглэхийн өмнө бохирдсон эсвэл тос болсон тохиолдолд гарыг угаах);
- Гараа тогтмол угааж байх, боломжгүй бол гараа ариутгах;
- Нүүр, маск / нүүрний хаалтыг бохирдуулахаас зайлсхийж аль болох хүрэхгүй байх;
- Чийгтэй, нойтон, бохирдсон эсвэл бохирдсон байж болзошгүй гараар маск эсвэл нүүрний хаалтыг солихгүй байх, бохирдсон, норсон маскийг дахин хэрэглэхгүй шууд хаях;
- Өдөр бүр маск эсвэл нүүрний хаалтын хамгийн багадаа 4 цаг тутамд (зарим төрлийн маск эсвэл нүүрний хаалт хэрэглэхийг зөвлөдөг хугацаа 4 цаг), шаардлагатай бол түүнээс ойр хугацаанд солих;
- Маск, нүүрний хаалтыг авсан тохиолдолд битүүмжилсэн саванд хийж, бусад гадаргуугг бохирдуулахгүй байх;
- Угаадаг материалтай маск бол хэрэглэх бүрийн өмнө угаасан байх / дараа дахин ашиглах боломжтой маск эсвэл нүүрний хаалтыг өндөр температурт угаах;
- Угааж болдоггүй материалаар хийсэн маск эсвэл нүүрний хаалтыг нэг удаагийн хэрэглээний дараа заавал устгах, хаях;
- Боломжтой бол маск хаалт хэрэглэсэн ч хүн хоорондын аюулгүйн зайн удирдамжийг үргэлжлүүлэн дагаж мөрдөх.

## 12. Ажиллагаа




### 12.1 Ерөнхий

Байгууллага нь 4-р зүйлд заасан эрсдэлийг арилгах, үүнд гэртээ ажиллах, хүн хоорондын аюулгүйн зайг баримтлах, ажлын байран дахь аюулгүй ажиллагааны бусад арга хэмжээ, хяналтыг хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зэрэг үйл явцыг хангаж байх ёстой.

Байгууллагын нэвтрүүлсэн арга хэмжээ нь одоо байгаа аюулгүй ажиллагааны арга хэмжээнд сөргөөр нөлөөлж байгаа эсэх, эсвэл аюулгүй ажиллагааны шинэ эрсдэлийг бий болгож байгаа эсэхийг үнэлж, эдгээр эрсдэлийг арилгах арга хэмжээ авах ёстой (Хавсралт А-г үзнэ үү).

Байгууллага нь хүмүүсийг чанга ярих, хашгирч ярихыг багасгахын тулд ажлын байран дахь дуу чимээг боломжит хэмжээнд хүртэл бууруулах арга хэмжээ авах хэрэгтэй (жишээлбэл, хөгжмийг багасгах, үс хатаагч гэх мэт төхөөрөмж ашиглах хугацааг багасгах). Чанга ярих, дуугаа өндөрсгөх түүний дотор хашгирах, дуулах болон бусад дуут проекц нь агаар дуслаар халдвар дамжуулах хүрээг нэмэгдүүлэх боломжтой. Дуу чимээг багасгах зайлшгүй шаардлага нь маск, нүүрний хаалт хэрэглэсэн хүмүүс хоорондоо харилцах, мөн хүн хоорондын аюулгүйн зайг баримтлах газарт ярьж байгаа зүйлс нь хоорондоо сонсогдохгүй байх эрсдэлтэй. (жишээлбэл үсчин, шивээсчин, физик эмчилгээний эмч, бар, ресторан гэх мэт хүн хоорондын аюулгүйн зайг баримтлах боломжгүй үйлчилгээний газрууд)

Хүн хоорондын аюулгүйн зайн удирдамжийг бүрэн дагаж мөрдөх боломжгүй үйл ажиллагаа, нөхцөл байдалд байгууллага 4.6-д заасан арга хэмжээг хэрэгжүүлж, оролцсон цаг хугацааг аль болох богино байлгахыг баталгаажуулах ёстой.

Хэрэв аливаа ажиллагаа нь хүн хоорондын аюулгүйн зайн талаархи удирдамжийг дагаж мөрдөх эсвэл ажилтнуудын хуваарилагдсан баг эсвэл хосоос бусад хүмүүстэй харилцах шаардлагатай бол тухайн байгууллага аюулгүй үйл ажиллагаа явуулж чадах эсэх, боломжгүй бол үйл ажиллагааг зогсоох шаардлагыг дахин үнэлэх ёстой.

Аюултай орчинд ажиллахыг ямар ч ажилтан зөвшөөрөх ёсгүй.

### 12.2 Ажлын байрандаа эргэж очих

Байгууллага нь ажлын байран дахь өөрчлөлт, ажлын байран дээр буцаж ирэхийг бүх ажилтнуудад мэдээлэх үйл явцыг боловсруулж, нөхцөл байдал өөрчлөгдөхөд үүнийг тогтмол хянаж, шинэчилж байх ёстой. Энэ нь ажилдаа эргэж ирэхээс өмнө өгсөн мэдээлэл, харилцаанаас гадна тодорхой үүрэг эсвэл үйл ажиллагааны удирдамжийг багтаасан байх ёстой.

Байгууллага нь:

- Ажлын байран дээрээ эргэж ирсэн, эсвэл өөр газар ажиллаж байсан, эсвэл өөр газарт очсон бүх ажилтнуудыг ирэхээс өмнө ямар шаардлага хангах ёстой талаар бүрэн заавар, мэдээллээр хангах;
- Ажилтнуудын тоо цөөрсөн тохиолдолд үүсч болзошгүй аюулын талаар мэдээлэх;
- Хүн хоорондын аюулгүйн зайг идэвхжүүлэхийн тулд ажлын байранд нэг удаа бөөнөөр орох ажилтны тоо, зааварчилгаа өгч, авч буй ажилтнуудын тоог хязгаарлах;
- Боломжтой бол ажлын байранд нэвтрэхээс өмнөх зааварчилгааг гаднах зай талбайд өгөх талаар бодолцох.

Байгууллага нь КОВИД -19-ийн шинж тэмдгүүдийн талаар мэдээллийг сайжруулж, ажилтнууд болон бусад хүмүүсийг (жишээлбэл, зочид, үйлчилгээний хэрэглэгчид) ажлын байранд орохоос өмнө эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдах зохих процессыг бий болгох

ёстой. Үүнд ажилтан, зочин өөрөө тайлагнах болон / эсвэл биеийн халууныг шалгах ажлыг багтааж болно.

Зөвлөмж, зөвлөгөөг эрүүл мэндийн мэргэжилтнүүд, байгууллагын дотоод нөөц бололцоогоор эсвэл гадны үйлчилгээ, мэргэжлийн байгууллагуудтай зөвлөлдөх замаар өгөх боломжтой.

### 12.3 Ажлын байранд орох, гарах

Байгууллага нь хүн хоорондын аюулгүйн зайг баримтлах заавρыг аль болох дагаж мөрдөх ёстой бөгөөд орох, гарахдаа гараа угаах (эсвэл боломжгүй бол гараа ариутгах) шаардлагатай.

Байгууллага нь дараахь үйл ажиллагааг зохион байгуулах ёстой.

- Орох, гарах цэгүүд дээр бөөгнөрөх байдлыг багасгах үүднээс орох, гарах цагийг заавал бүртгэлжүүлэхгүй байх;
- Боломжтой бол орох, гарах цэгийг нэмж өгөх;
- Боломжтой бол дугуйн зогсоол гэх мэт нэмэлт зогсоол эсвэл байгууламжаар хангах;
- Байгууллагын ашигладаг тээврийн хэрэгсэл, тухайлбал микроавтобусны зорчигчдын тоог хязгаарлах (үүнд суудал хоосон орхих, алгасах гэх мэт);
- Боломжтой бол шал, ханан дээр хүн хоорондын аюулгүйн зайн зураг, постерийг ашиглах, орох, гарах цэгүүдэд нэг чиглэлийн системийг нэвтрүүлэх;
- Өндөр эрсдэлтэй ажлын хэсэг буюу талбайд (жишээлбэл, механик туршилтын талбай, чийгтэй нөхцөлд ажиллах лаборатори) орох, гарах цэгийг тусад нь бий болгох;
- Товчлуур, цаг бүртгэлийн машин, электрон нэвтрүүлэх цэг зэрэг мэдрэгчтэй аюулгүй байдлын төхөөрөмжүүдийг тогтмол ариутгаж, нэвтрэх карт болон уншигч төхөөрөмжийн хоорндын зайг тохируулах;
- КОВИД-19-тэй холбоотой эрсдэлийг удирдах зорилгоор нэвтрүүлсэн аюулгүй байдлын арга хэмжээг тооцоологүй аюулгүй ажиллагааны нэмэлт эрсдэлийг бий болгохгүй байх тал дээр анхаарах (Хавсралт А-г үзнэ үү);

- Ажилтнууд, үйлчилгээ эрхлэгчдийн хувцас, цүнхийг хадгалах газрын нэг хүнд зориулсан байдлаар тохируулах;
- Ажилтнуудыг ажлын байранд хувцас, тоног төхөөрөмж солих өрөөнд аюулгүйн зай, эрүүл ахуйн шаардлагуудыг хангуулах;
- Боломжтой бол хувцас, тоног төхөөрөмжийг (жишээлбэл, дүрэмт хувцас, каск, дуулга) зэргийн ариутгах, цэвэрлэх.

### 12.4 Ажлын байрны хоорондох хөдөлгөөн

Байгууллага нь ажилтан болон бусад хүмүүсийг ажлын байранд очих, шилжих үйл явцад боломжийн хэрээр хүн хоорондын аюулгүйн зайн удирдамжийг хадгалах үйл явцыг хангаж байх ёстой.

Аюулгүй хөдөлгөөнийг идэвхжүүлэхийн тулд байгууллага дараахь арга хэмжээг авч үзэх хэрэгтэй.

- Барилга байгууламж, талбайн доторх хөдөлгөөнийг багасгах (жишээлбэл, тэнд байх шаардлагатай ажилтнуудад ажлын тодорхой хэсэгт нэвтрэх боломжийг хязгаарлах, зөвшөөрөгдсөн тохиолдолд радио эсвэл утас ашиглахыг дэмжих, хэрэв эдгээр тоног төхөөрөмжийг дамжуулан хэрэглэдэг бол ашиглалтын хооронд цэвэрлэх);
- Хяналттай нэвтрэх шаардлагатай газруудад гараар хүрэлцэхгүйгээр нэвтрэх хяналтыг идэвхжүүлэх (жишээлбэл, автомат хаалга);
- Гадаргуугийн бохирдлыг бууруулахын тулд гар хүрч нэвтрэх хяналтыг (жишээлбэл, электрон хаалт, товчлуур) ашиглахгүй байх;
- Эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж буй ажилтнууд болон шинжилгээнд хамрагдаж буй хүмүүсийн хооронд ойртохоос зайлсхийх үүднээс хаалт суурилуулах (жишээлбэл, орц, ажлын байрны хооронд болон эрүүл мэндийн үзлэг явагдаж буй бусад газарт);
- Ажил гүйцэтгэх хэсгийн хүмүүсийн тоог нэг доор бөөгнөрөх байдлыг багасгахын тулд баг / хосоор ажиллах, үүрэг даалгаврыг дуусгах тодорхой хугацаа зааж өгөх;

- Барилга байгууламжаар дамжин өнгөрөх нэг чиглэлийн системийг нэвтрүүлэх, урт буюу нарийн коридор, шат, явган хүний зам, эргэлт зэрэгт онцгой анхаарал хандуулах;
- Энгийн шат ашиглахыг дэмжих, цахилгаан шат / лифтний багтаамжийг багасгах, гар ариутгагч төхөөрөмжөөр хангах, гараар хүрэлцэх газруудыг (жишээлбэл, бариул, товчлуур) тогтмол цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг хангах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст цахилгаан шат / цахилгаан шатанд аюулгүй нэвтрэх, ашиглах боломжийг олгох (нүдний шил, бээлий) цэвэрлэх, ариутгах, угаах.

### 12.5 Ажлын бүс ба ажлын байр

Байгууллага нь боломжийн хэрээр ажлын бүс, ажлын байран дахь хүн хоорондын аюулгүйн зайн удирдамжийг хангаж байх ёстой.

Аюулгүй ажиллагааг хөнгөвчлөхийн тулд байгууллага дараахь зүйлийг хийх ёстой.

- Ажлын бүсүүдийг судалж, боломжтой бол ажлын байруудыг хооронд нь аюулгүйн зайтай байлгахын тулд ажил гүйцэтгэх тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлэх, хэрэв энэ нь бусад ажилтнуудын ажиллах зай талбайгаар дамжин өнгөрч байгаа бол ажиллаж буй ажилтнуудын аюулгүй байдалд анхаарах хэрэгтэй.
- Ажлын байранд ажилтнууд өөд өөдөөсөө харж биш зэрэгцээ, ар араасаа эсвэл диагональ байхаар зохион байгуулах;
- Зарим ажлын байрны ашиглалтыг хориглох, эсвэл ажлын байр нь санал болгож буй зайнаас бага бол тусгаарлах дэлгэц, хаалт ашиглах;
- Боломжтой бол ажлын байр, тоног төхөөрөмжийг ганцаарчлан ажиллахаар хуваарилах, эсвэл боломжгүй тохиолдолд баг / хосыг хуваарилах (жишээлбэл, дуудлагын төв, сургалтын байгууламж), «халуун суудал солих» болон бусад үйл ажиллагааг хязгаарлах;

- Хүн хоорондын аюулгүйн зайны санал болгосон удирдамжийг зааж өгөхийн тулд шал эсвэл хананы тэмдэг тэмдэглэгээг ашиглах;
- Хүн хоорондын аюулгүйн зайг боломжит хэмжээнд хэрэгжүүлэхийн тулд биеэр хүрэлцэхгүй байх хаалт хашилтыг аюулгүй байдлаар бий болгож, энэ тохиолдолд аюулгүй ажиллагааны бусад эрсдэлийг нэвтрүүлэхгүйгээр эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сөргөөр нөлөөлөхгүйгээр хийх;
- Хязгаарлагдмал орон зайд хүн хоорондын аюулгүйн зайг гаргах боломжийг олгохын тулд ажлын бүс дэх ажилтнуудын тоог багасгах;
- Гараар заавал хүрэлцэх эд зүйлс, дундын төхөөрөмжийн хэрэглээг хязгаарлаж, ойр ойрхон цэвэрлэх, халдваргүйжүүлэх ажлыг идэвхжүүлнэ.

### 12.6 Нийтийн эзэмшлийн талбайг ашиглах

#### 12.6.1 Ерөнхий зүйл

12.6.1.1 Байгууллага нь зайлшгүй шаардлагатай нийтлэг талбайн аюулгүй ашиглалтыг ашиглах үйл явцыг дараахь байдлаар оруулна.

- Ойр ойрхон, төрөл бүрийн хүмүүсийн хэрэглээний хоорондох цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт;
- Нийтийн эзэмшлийн талбай дахь хүмүүсийн нэг удаа нэвтрэх тоог хязгаарлах;
- Хүмүүсийн нийтлэг газар байх хугацааг хязгаарлах;
- Хүн хоорондын аюулгүйн зайг баримтлах.

12.6.1.2 Байгууллага нь шаардлагатай бол дараахь зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй.

- Бусад байгууллагуудтай хамтарч ажиллахад ажилтнууд орох, гарах цагийг солих цахилгаан шат / өргүүр, хүлээн авах, коридор, хамгаалалтын цэг зэрэг нийтлэг газрын хөл хөдөлгөөнийг багасгах;

- Завсарлагааны хугацааг өөрчилж, боломжтой бол завсарлагаанаар аюулгүй, гадна орчинд байх;
- Ажлын байрны гаднах зайг ашиглахыг дэмжих;
- Ажлын байрны бусад хэсэгт нэмэлт нийтлэг орон зайг бий болгох;
- Хүлээн авалт эсвэл ижил төстэй газарт ажилтнуудыг тусгаарлах дэлгэц, хаалт суурилуулах;
- Ажилтнуудыг өөрсдөө хоол хүнсээ авчрахыг уриалах, эсвэл шаардлагатай бол цайны газар нээхгүйн тулд савласан хоолоор хангах;
- Аяга, таваг, халбага зэрэг дундын нөөцийг дамжуулан ашиглахаас зайлсхийх, усны цорго, ундааны хуваарилагч, ус буцалгагчийг хэрэглээ болгоны дараа хэрэглэгч цэвэрлэж, ариутгаж байх;
- Хүн хоорондын аюулгүйн зайг хангах, нүүр тулсан харилцан үйлчлэлийг багасгах үүднээс хөдөлдөг, дугуйтай суудал, ширээ ашиглах;
- Ажлын цагаар ажилтнуудыг ажлын байран дээрээ байлгахыг уриалж (ажлын гаднах орчин хамаарна) ажлын байрнаас гарах тохиолдолд хүн хоорондын аюулгүйн зайг дагаж мөрдөхийг шаардах;
- Хувцас солих өрөө, шүршүүр болон бусад нийтлэг байгууламж (жишээлбэл, хүүхдийн өрөө, гэр бүлийн өрөө, бясалгал, мөргөлийн өрөө, хөл угаах газар) ашиглалтыг зохицуулах;
- Хувийн эд зүйлсээ шүүгээ гэх мэт хувийн орон зайд хадгалахыг дэмжих.

### 12.6.2 Ариун цэврийн өрөө ашиглах

Байгууллага нь ажилтнууд болон бусад сонирхогч талууд, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан ариун цэврийн байгууламжийг аюулгүй ашиглахад туслах нэмэлт арга хэмжээг авч үзэх хэрэгтэй. Үүнд дараахь арга хэмжээ орно.

- Олон хүн цуглахаас зайлсхийхийн тулд ариун цэврийн өрөөний ашиглалтыг зохицуулах;
- Цэвэрлэгээ, ариутгалыг илүү ойртуулах, сайжруулах (ариун цэврийн өрөөний суудал, түгжээ, угаалтуур, бариул, өргөх байгууламж зэрэг хүрэлцэх цэгүүд орно) ба хог хаягдлыг зайлуулах;
- Суултуурыг гүн цэвэрлэх зорилгоор түр хугацаагаар хаасан бол хэрэглэгчдийг хамгийн ойр байгаа бие засах газар руу чиглүүлэх зорилгоор тэмдэг тэмдэглэгээг ашиглах;
- Суултуурын тоог хязгаарлах, хоорондын зайг баримтлах, зарим суултуурыг ашиглахгүйгээр хаах;
- Суултуурын усыг татахаас өмнө хаалт, тагийг хаахыг хэрэглэгчдэд уриалах тэмдэглэгээг ашиглах;
- Хязгаарлагдмал орчинд биш, харин байгууламжийн гадна бие засах газрыг бий болгох;
- Тусгай хэрэгцээт хэрэглэгчдийг харгалзан ажлын байрны доторх нэг зориулалтын байгууламжийг ашиглахыг ажилтан эсвэл зочдоос хүсэх;
- Цаасан алчуур, салфеткаар хангах, цаасан алчуур дууссан эсэхийг хянах, хадгалах, хог хаягдлыг байнга, аюулгүй хаях нөхцлийг бүрдүүлэх;
- Гараар хүрэлцэх тоног төхөөрөмжөөс илүү автомат ба хөлөөр ажилладаг төхөөрөмж ашиглах (жишээлбэл, мэдрэгчээр ажилладаг цорго, саван тараагч, угаалтуур, хөлөөр ажилладаг хогийн сав);
- Ариун цэврийн хэрэгсэл, эд зүйлсийн хангамж (саван, ариутгагч, цаасан алчуур, ариун цэврийн цаас гэх мэт) -ийг хянах, дүүргэх ажлыг нэмэгдүүлэх.

### 12.7 Уулзалт хийх, ажлын байранд зочлох

12.7.1 Байгууллага нь биеэр байранд зочлохыг хязгаарлаж, гадны болон дотоод нүүр тулсан уулзалтыг аль болох багасгах, ялангуяа хязгаарлалт тогтоогдсон үед алсын зайнаас ажиллах технологийг

ашиглах ёстой.

12.7.2 Хэрэв нүүр нүүрээ харан уулзах эсвэл ажлын байран дээр зочлох нь зайлшгүй шаардлагатай бол байгууллага нь зочинд эрүүл мэндийн үзлэг, эрүүл мэндийн байдлын талаар өөрийгөө тайлагнах зэргийг зочлохоос өмнө сануулах, барилга руу аюулгүй нэвтрэх талаар заавар, үйл явцыг мэдээлэх ёстой.

Байгууллага нь:

- Зөвхөн шаардлагатай зочдод нэвтрэх эрхийг хязгаартайгаар өгөх;
- Зочдыг хаанаас ирж байгааг, аюулгүй байдлын нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг харгалзан үзэх;
- Ажлын байранд нэг удаа нэвтрэх зочдын тоог хязгаарлах;
- Тодорхой цаг хугацаанд зочлохыг хязгаарлах;
- Боломжтой бол зочдод тусдаа бие засах газар бий болгох;
- Харилцан үйлчлэлийг багасгахын тулд зайлшгүй шаардлагатай үйлчилгээ болон бусад гэрээт гүйцэтгэгчдийн уулзалтын хуваарийг шинэчлэх (жишээлбэл, ажилтан эсвэл үйлчлүүлэгчидтэй харилцах харилцааг хязгаарлахын тулд ажлын бус цагаар);
- Холбоо барих, мөшгилтийг сайжруулахын тулд зочдын дэлгэрэнгүй мэдээллийг тэмдэглэх (жишээлбэл нэр, огноо, айлчлалыг зохион байгуулж буй хүн, ажлын байран дахь бусад хүмүүсийн нэр, эсвэл зочинтой ойр эсвэл удаан хугацаагаар холбоо барьсан). тохиролцсон хугацааны дараа хамгаалагдсан, устгасан (14 хоногоос доошгүй буюу албан ёсны зааврын дагуу);
- Зочдын дэлгэрэнгүй мэдээллийг хэрхэн бүртгэх, зочид ажлын байранд хэрхэн яаж гарахыг хянах (жишээлбэл, хүлээн авагчийн бичсэн нийтлэг үзэгнээс зайлсхийх, орох, гарах нэг талын систем ашиглах, нэг удаагийн зочны тэмдгийг ашиглах зэргээр бүртгэсэн дэлгэрэнгүй мэдээлэл);
- Зочдод хүн хоорондын аюулгүйн зайн удирдамж, аюулгүй байдлын бусад арга хэмжээ, хяналтыг дагаж мөрдөхийг шаардах;

- Нэвтрэх шаардлага хангасан, уулзалтанд оролцож буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст боломжит тохируулга хийх.

12.7.3 Хэрэв биеэр уулзах уулзалт зайлшгүй шаардлагатай бол байгууллага дараахь зүйлийг хийх ёстой.

- Зайлшгүй шаардлагатай хүмүүсийн хамгийн бага тоогоор оролцоог хязгаарлаж, хон хооорондын аюулгүйн зайг мөрдөх удирдамжийг баримтлах;
- Дундын зүйл хэрэглэхээс зайлсхийх (жишээлбэл, үзэг, ус эсвэл кофены сав);
- Хурлын өрөөнд гар ариутгагч бодис байршуулах;
- Боломжтой бол гадаа эсвэл агааржуулалт сайтай өрөөнд уулзалт хийх;
- Хүн хоорондын аюулгүйн зайн зөвшөөрөгдөх зааврыг зааж өгөхийн тулд шал эсвэл хананы тэмдэглэгээг ашиглана уу.

## 12.8 Олон нийттэй ажиллах, харилцах

